



УЛААНБААТАР ХОТЫН НИЙТИЙН АЖ АХУЙГ САЙЖРУУЛАХ ТӨСЛИЙН 2012 ОНЫ ТАЙЛАН, 2013 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

УЛААНБААТАР ХОТ
2013

Тайлан бэлтгэсэн:

Д.Цэндсүрэн

М.Энхбаяр

Ж.Батбуянт

Д.Нямдорж

Б.Нямсүрэн

О.Хулан

Э.Батжаргал

Ю.Пүрэвсүрэн

Хянан тохиолдуулсан:

Л.Бадамхорлоо

АГУУЛГА

| | |
|--------------------------------------------------------------------------|----|
| Товчилсон үгийн тайлбар | 5 |
| Хүснэгтийн жагсаалт..... | 6 |
| Зургийн жагсаалт..... | 6 |
| БҮЛЭГ 1. Танилцуулга..... | 7 |
| 1.1 Төслийн багийн танилцуулга | 7 |
| 1.2 Төслийн 2012 оны онцлог үйл явдлууд..... | 8 |
| БҮЛЭГ 2. Иргэдийн оролцоог дэмжих ХОЁР ДАХЬ ТӨСӨЛ..... | 9 |
| 2.1 Танилцуулга | 9 |
| 2.2 2012 оны төлөвлөгөө ба биелэлт | 9 |
| 2.3 Олон нийтийн хөгжил, зохион байгуулалт | 11 |
| 2.3.1 Чадавхийг бэхжүүлэх нь | 11 |
| 2.3.2 Олон нийтийн зохион байгуулалт | 12 |
| 2.3.3 Хамтын ажиллагаа, харилцаа холбоо..... | 13 |
| 2.3.4 Үр шим хүртэгсдийн тоо..... | 14 |
| 2.3.5 Хүндрэл бэрхшээл, сургамж..... | 14 |
| 2.4 Барилгын ажил, техникийн асуудлууд | 15 |
| 2.4.1 Барилгын ажлын үйл явц..... | 15 |
| 2.4.2 Барилгын ажилд тавигдсан хяналт, үнэлгээ..... | 15 |
| 2.4.3 Үр шим хүртэгчдийн тоо..... | 16 |
| 2.4.4 Хүндрэл бэрхшээл, сургамж..... | 17 |
| 2.5 Худалдан авах ажиллагаа | 17 |
| 2.5.1 Танилцуулга..... | 17 |
| 2.5.2 Төлөвлөлт | 17 |
| 2.5.3 Сонгон шалгаруулалтын бэлтгэл ажлууд..... | 19 |
| 2.5.4 Гэрээт ажлын хэрэгжилт | 21 |
| 2.5.5 Сургалт..... | 21 |
| 2.5.6 Хяналт | 22 |
| 2.5.7 Статистик үзүүлэлт | 22 |
| 2.6 Санхүүжилт..... | 22 |
| 2.6.1 Төслийн хөрөнгө зарцуулалтын байдал..... | 22 |
| 2.6.2 Үр шим хүртэгчид..... | 23 |
| 2.7 Дүгнэлт | 24 |
| 2.7.1 Олон нийтийн зохион байгуулалт, хамтын ажиллагааны чиглэлээр:..... | 24 |

| | | |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------|----|
| 2.7.2 | Худалдан авах ажиллагааны чиглэлээр: | 25 |
| БҮЛЭГ 3. Гэр хорооллын айл өрхийг цэвэр, бохир усны системд холбох загвар төсөл.. | | |
| 3.1 | Дамбадаржаагийн загвар төслийн талаар авсан арга хэмжээ | 26 |
| 3.2 | Судалгаанууд..... | 27 |
| 3.3 | Дүгнэлт | 28 |
| 3.4 | ХӨРӨНГӨ ЗАРЦУУЛАЛТ | 29 |
| БҮЛЭГ 4. Улаанбаатар цэвэр агаар төсөл | | |
| 4.1 | Удирдлага зохион байгуулалтын талаар авсан арга хэмжээ | 30 |
| 4.1.1 | Төслийн бэлтгэл ажил..... | 30 |
| 4.2 | Төсөл хүчин төгөлдөр болж батлагдав..... | 31 |
| 4.3 | Төслийн худалдан авах ажиллагаа..... | 31 |
| 4.4 | Үндэсний болон хотын бодлоготой уялдуулах нь..... | 33 |
| 4.5 | УЛААНБААТАР ЦЭВЭР АГААР ТӨСЛИЙН ХӨРӨНГӨ ЗАРЦУУЛАЛТ | 33 |
| БҮЛЭГ 5. Гамшгийн эрсдэлийн менежментийг сайжруулах төсөл..... | | |
| 5.1 | Удирдлага зохион байгуулалтын талаар авсан арга хэмжээ | 34 |
| 5.1.1 | Төслийн бэлтгэл ажил..... | 34 |
| 5.2 | Төсөл батлагдаж, хүчин төгөлдөр болсон нь..... | 34 |
| 5.3 | Худалдан авах ажиллагааны талаар хийсэн ажлууд | 35 |
| 5.3.1 | Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө | 35 |
| 5.3.2 | Сонгон шалгаруулалт эхлэсэн гэрээнүүд, явц..... | 35 |
| 5.4 | Төслийг улсын болон хотын бодлоготой уялдуулах талаар авсан арга хэмжээ ... | 35 |
| 5.4.1 | Дэлхийн банкны багийн ажлын үр дүн..... | 35 |
| 5.4.2 | Онцгой байдлын асуудал хариуцсан байгууллагуудын хамтын ажиллагаа, Сургалт 35 | |
| 5.5 | Дүгнэлт | 36 |
| 5.6 | ХӨРӨНГӨ ЗАРЦУУЛАЛТ | 36 |
| БҮЛЭГ 6. улаанбаатар хотын нийтийн аж ахуйг сайжруулах гурав дахь Төсөл..... | | |
| 6.1 | Төслийн бэлтгэл ажил | 37 |
| 6.2 | Дэлхийн банкны хяналтын баг..... | 37 |
| 6.3 | Төслийн ТЭЗҮ боловсруулах судалгаа..... | 38 |
| 6.4 | Төслийн бүтэц, бүрэлдэхүүн хэсгүүд | 39 |
| 6.5 | Дүгнэлт | 39 |
| БҮЛЭГ 7. ЗАСАГ ДАРГЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД УБ-ЦЭВЭР АГААР, ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ДЭМЖИХ, ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ТӨСЛҮҮДЭЭР ТҮН-ИЙН ХИЙЖ ГҮЙЦЭТГЭХ АЖЛУУД /2013/ | | |
| | | 40 |

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

| | |
|---------|-----------------------------------------------------|
| БОНУ | Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ |
| БУА | Барилга угсралтын ажил |
| БХБЯ | Барилга хот байгуулалтын яам |
| БХБТГ | Барилга хот байгуулалт төлөвлөлтийн газар |
| БШУЯ | Боловсрол шинжлэх ухааны яам |
| ГЭМСТ | Гамшгийн эрсдэлийн менежментийг сайжруулах төсөл |
| ДСК | Дулааны сүлжээ компани |
| ДБ | Дэлхийн банк |
| ЗАА | Захирагчийн ажлын алба |
| НАЧА | Нийслэлийн агаарын чанарын алба |
| НБХГ | Нийслэлийн байгаль хамгаалах газар |
| НЗД | Нийслэлийн засаг дарга |
| НЗДТГ | Нийслэлийн засаг даргын тамгын газар |
| НОБГ | Нийслэлийн онцгой байдлын газар |
| НХОГ | Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар |
| ИБХ | Инженерийн байгууламжийн хэлтэс |
| ИОДТ | Иргэдийн оролцоог дэмжих төсөл |
| ХАА | Худалдан авах ажиллагаа |
| ХНААХ | Хот, Нийтийн аж ахуйн хэлтэс |
| ХТГ | Хот тохижилтын газар |
| ОБЕГ | Онцгой байдлын ерөнхий газар |
| ОУХА | Олон улсын хөгжлийн ассоциаци |
| УБНААСТ | Улаанбаатар хотын Нийтийн аж ахуйг сайжруулах төсөл |
| УСУГ | Ус сувгийн удирдах газар |
| УБЦАТ | Улаанбаатар Цэвэр агаар төсөл |
| СШББ | Сонгон шалгаруулалтын баримт бичиг |
| СЯ | Сангийн яам |
| ТЭЦ | Дулааны цахилгаан станц |
| ТУН | Төслийг удирдах нэгж |
| ТУХ | Төслийг удирдах хороо |
| ТХН | Төсөл хэрэгжүүлэх нэгж |
| ТЭЗҮБ | Техник эдийн засгийн үндэслэл боловсруулах |
| ЭХЯ | Эрчим хүчний яам |
| ЯНХС | Японы нийгмийн хөгжлийн сан |

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- Хүснэгт 1. Төсөл хэрэгжиж буй хороод
- Хүснэгт 2. Төслийн 2012 оны төлөвлөлт ба хэрэгжилт
- Хүснэгт 3. Үр шим хүртэгсэд ба сэтгэл ханамжийн үнэлгээ
- Хүснэгт 4. Үр шим хүртэгчдийн тоо
- Хүснэгт 5. Төслийн 2012 оны ХАА-ны төлөвлөгөөний хураангуй
- Хүснэгт 6. 2012 онд төлөвлөсөн гэрээт ажлын биелэлт.
- Хүснэгт 7. Үнэлгээний хорооны мэдээлэл
- Хүснэгт 8. ХАА-нд зарцуулсан хугацаа
- Хүснэгт 9. Буцалтгүй тусламжийн хөрөнгөөр 6 дүүрэгтхийсэн бүтээн байгуулалтын дүн

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

- Зураг 1. Төслийг удирдах нэгжийн хамт олон, 2012 он
- Зураг 2. Бэлтгэл бүлгийн сургалт
- Зураг 3. Ахлах бүлгийн сургалт
- Зураг 4. Өрхийн хөгжил аян
- Зураг 5. Бүлгийн үнэлгээ
- Зураг 6. Зөвлөлдөх уулзалт
- Зураг 7. Холбоодын уралдаан
- Зураг 8. Нийтийн хамарсан хог цэвэрлэгээ
- Зураг 9. Үзэсгэлэн
- Зураг 10. “Хөгжлийн хэмнэл” арга зүйн гарын авлага
- Зураг 11. Жүжигчилсэн тоглолт
- Зураг 12. Нийгмийн ажилтнуудын уулзалт
- Зураг 13. Сити тойлет нийтийн бие засах газар
- Зураг 14. ЧД-ийн 18-р хороо, Долоон буудлын эцэст “City toilet” Нийтийн бие засах газрын нээлтийн үеэр
- Зураг 15. Явган гүүр
- Зураг 16. Хүүхэд залуучуудын хөгжлийн төв
- Зураг 17. Орлогын зарцуулалт
- Зураг 18. Ажил эрхлэлтийн байдал
- Зураг 19. Судалгааны үр дүн
- Зураг 20. Айл өрхүүдэд гарсан өөрчлөлтүүд
- Зураг 21. ТУХ-ны хурлын үеэр.
- Зураг 22. БЗД-ийн 21-р хороонд болсон үер, 2012 оны 6-р сар
- Зураг 23. 2012 оны 1-р сарын 30 ТЭЗҮ боловсруулах судалгааны эцсийн хэлэлцүүлгийг хийсэн.

БҮЛЭГ 1. ТАНИЛЦУУЛГА

1.1 ТӨСЛИЙН БАГИЙН ТАНИЛЦУУЛГА

Төслийг Удирдах Нэгж нь 2012 онд инженер техник, санхүү, нийгмийн ажилтан, худалдан авах ажиллагаа болон гэрээний мэргэжилтэн, мэдээлэл технологийн ажилтан зэрэг 11 боловсон хүчний бүрэлдэхүүнтэйгээр Нийслэлийн 6 дүүрэгт буцалтгүй тусламж, хөнгөлттэй зээлээр хэрэгжиж буй нийт 4 төслийн бэлтгэл ажил болон хэрэгжилтийг хариуцан ажилласан. Дэлхийн банктэй хамтран боловсруулсан ТУН-ын “Үйл ажиллагааны гарын авлага”-г баримтлан төслийн хэрэгжилт, хяналт үнэлгээ, ажилтнуудын гүйцэтгэлийн чанар болон түүнд тавигдах мэргэжлийн шаардлага, стандартыг сайжруулсан нь багийн чадавхийг бэхжүүлэх томоохон алхам болов.

2012 онд нийт ажилтнуудын 81% нь мэргэжил ур чадвараа дээшлүүлж, гүйцэтгэж буй ажил үүргийн дагуу Дэлхийн банкны “Газар ашиглалт, төлөвлөлт”



Зураг 1. Төслийг удирдах нэгжийн хамт олон, 2012 он

онлайн курст ажилтан Д.Цэндсүрэн, Б.Нямсүрэн, “Гамшгийн эрсдэлийн менежмент” курст Э.Батжаргал нар суралцаж гэрчилгээ авсанаас гадна ТУН-ийн 5 ажилтан Худалдан авах ажиллагааны хуулийн сургалтад сууж, Сангийн яамны АЗ гэрчилгээг авлаа. Мөн ажилтнууд “Нийгмийн хариуцлагын сүлжээг бэхжүүлэх нь”, “Газар зохион байгуулалтын хууль” зэрэг хэд хэдэн сургалт семинарт хамрагдаж, мэргэжил, ур чадвараа дээшлүүлэв.

Гүйцэтгэлд тулгуурласан үнэлгээний загвар, хандлагыг төслийг удирдах, хэрэгжүүлэх явцад нэвтрүүлсэн нь ажилтнуудыг хөгжүүлэх томоохон хөшүүрэг болохын зэрэгцээ бүтээмжийг нэмэгдүүлэх, нэгж ажилтны цаг ашиглалтыг сайжруулахад эерэг нөлөөллийг үзүүлж байна.

1.2 ТӨСЛИЙН 2012 ОНЫ ОНЦЛОГ ҮЙЛ ЯВДЛУУД

УЛААНБААТАР ЦЭВЭР АГААР ТӨСӨЛ




ДБ-ны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжих ҮБ Цэвэр агаар төсөл 2012 оны 5-р сарын 18-нд УИХ-аар батлагдав. Төслийн хөрөнгө зарцуулалтын эрх 2012 оны 12-р сарын 18-нд нээгдэв.

ГАМШГИЙН ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ



Японы PHRD буцалтгүй тусламжаар хэрэгжих Улаанбаатар хотын гамшигийн эрсдэлийн менежментийг сайжруулах төсөл 2012 оны 6-р сарын 13-нд батлагдав.

ГЭР ХОРООЛЛЫН АЙЛ ӨРХИЙГ ЦЭВЭР, БОХИР УСНЫ СИСТЕМД ХОЛБОХ ЗАГВАР ТӨСӨЛ



Монгол улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг загвар төслийн ажилтай танилцав. 2012 оны 9-р сарын 3

УЛААНБААТАР ХОТЫН НИЙТИЙН АЖ АХУЙГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ



Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Э.Бат-Үүл төслийн үйл ажиллагаатай танилцав. 2012 оны 8-р сарын 18



УЛААНБААТАР ХОТЫН НИЙТИЙН АЖ АХУЙГ САЙЖРУУЛАХ **ТӨСЛИЙГ** **УДИРДАХ НЭГЖ ШАГНУУЛАВ**

Швейцарын Женев хотноо Олон улсын чанарын Business Initiative Directions (B.I.D)-аас Төслийг удирдах нэгжийг "Чанарын удирдлага" алтан цомоор шагнав. 2012 оны 3-р сарын 11

БҮЛЭГ 2. ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ДЭМЖИХХОЁР ДАХЬТӨСӨЛ

2.1 ТАНИЛЦУУЛГА

Иргэдийн оролцоог дэмжих төсөл нь Улаанбаатар хотын хязгаарлагдмал дэд бүтэц, нийгмийн үйлчилгээ бүхий гэр хорооллын 10,000 өрхийн орлогыг нэмэгдүүлэх, олон нийтийн оролцоонд тулгуурлан бичил дэд бүтцийг хөгжүүлэх туршлагыг өргөжүүлэх зорилготойгоор хэрэгжиж байна.

Төслийг Удирдах Нэгж нь буцалтгүй тусламжийн хэлэлцээрийн дагуу (i) олон нийтийн оролцоонд тулгуурласан дэд бүтцийн хөгжил, (ii) эрүүл мэнд, (iii) аюулгүй байдал, (iv) хүүхэд, залуучуудын хөгжил, (v) төслийн удирдлага, хяналт үнэлгээ, сургалт зэрэг үндсэн 5 бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд дунд бүсийн гэр хорооллын дараахи хороодод төслийг хэрэгжүүлж байна.

Хүснэгт 1. Төсөл хэрэгжиж буй хороод

| № | Дүүрэг | Хороо |
|---|----------------|------------------------|
| 1 | Сонгинохайрхан | 1,2,3,4,7,8,9,10,23,25 |
| 2 | Баянзүрх | 13,14,16,2,21,9 |
| 3 | Чингэлтэй | 13,14,15,16,18,17 |
| 4 | Хануул | 4,5,6,7,8 |
| 5 | Баянгол | 9,10,11 |
| 6 | Сүхбаатар | 12,13,15,17,18 |

2.2 2012 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ БА БИЕЛЭЛТ

Нийслэлийн Засаг Даргын Тамгын газраас 2012 оныг “Иргэдийн оролцоо, өрхийн хөгжлийг дэмжих жил” болгон зарлаж иргэний нийгмийн чадавхийг бэхжүүлэх, олон нийтийн оролцоог дэмжихэд чиглэгдсэн зорилтуудыг дэвшүүлсэн. Төслийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тухайн оны нийслэлийн нийгэм эдийн засгийн зорилтыг үндэслэн ТҮН нь дараахи төлөвлөгөөг боловсруулан 2012 онд хэрэгжүүлэв.

Хүснэгт 2. Төслийн 2012 оны төлөвлөлт ба хэрэгжилт

| Хугацаа | Ажил | Тайлбар |
|-----------------------------|----------------------------------------------|---------------------------------------------------------------------|
| 1. Томоохон барилгын ажлууд | | |
| 6-11 сар | Авто зам (1,25 км) | - 2013 онд гүйцэтгэхээр хойшлуулсан |
| 5-11 сар | Үерийн далан (0,4 км) | - Барилгын ажил дууссан - Техникийн комисс ажилласан |
| 5-9 сар | Явган гүүр(2 байршилд) | - Барьж байгуулан дүүргийн өмчид хүлээлгэн өгсөн |
| 5-9 сар | Гүний худаг (1 байршилд) | - Худгийг барьж байгуулан, дүүргийн өмчид хүлээлгэн өгсөн |
| 5-10 сар | Сити тойлет (1 байршилд) | - Улсын комисст хүлээлгэн өгсөн. |
| 4-12 сар | Хүүхэд залуучуудын хөгжлийн төв (1 байршилд) | - Барилгын ажил дууссан. Улсын комисс ажиллах бэлтгэл хангаж байна. |

БҮЛЭГ II. ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ДЭМЖИХ ХОЁР ДАХЬ ТӨСӨЛ

| Хугацаа | Ажил | Тайлбар |
|--------------------------------------------------|-------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| | Хяналтын камер | - Төлөвлөгөөнөөс хассан |
| 2. Иргэдийн оролцоотой барилгын ажлууд | | |
| 4-10 сар | Ус зайлуулах суваг (3 байршилд) | - БЗД-ийн 21-р хороонд 360м ус зайлуулах сувгийг иргэдийн оролцоонд тулгуурлан хийсэн боловч 2012 оны 6-р сарын 19-ны үерт урссан. - Энэ төрлийн ажлыг иргэдийн оролцоотойгоор хийх боломжгүй гэсэн шийдэлд хүрсэн тул Сонгинохайрхан болон Сүхбаатар дүүрэгт хийхээр төлөвлөсөн ус зайлуулах сувгийг хийгээгүй. |
| 5-11 сар | Явган хүний зам (17 байршилд) | - Нийтдээ 5.1 км зам барьсан. |
| 5-9 сар | Усны эх үүсвэр хамгаалах (1 байршилд) | - Нийслэлийн Байгаль орчныг хамгаалах газрын захиалгаар усны эх үүсвэрийн орчмыг хогоос цэвэрлэж, сагсны талбай байгуулан, хүлээлгэж өгсөн. |
| 4-11 сар | Олон нийтийн хөгжлийн төв (1 байршилд) | - Хэрэгжилтийн шатанд явж байна. |
| 4-11 сар | Тоглоомын талбай (7 байршилд) | - 7 тоглоомын талбайг байгуулан, дүүрэг, хороодод хүлээлгэн өгсөн. |
| 3. Зөвлөхийн үйлчилгээ | | |
| 1-10 сар | Жижиг ажлуудын зураг боловсруулах | - Ус зайлуулах суваг, хүүхдийн тоглоомын талбай, явган замын зураг хийгдсэн. |
| 1-4 сар | Томоохон ажлуудын зураг боловсруулах | - Авто зам, үерийн далан суваг, явган хүний гүүрийн зураг хийгдсэн. |
| 4. Олон нийтийн хөгжил, зохион байгуулалт | | |
| 1 сар | Бэлтгэл бүлгүүдийн багц сургалт | - 5 дүүргийн 17 иргэдийн бүлгийн 205 иргэн хамрагдав. |
| 2 сар | Иргэдийн бүлгүүдийн зөвлөлдөх уулзалт | - Нийт 103 хүн оролцов. |
| 3 сар | Ахлах бүлгүүдийн багц сургалт | - 6 дүүргийн 21 иргэдийн бүлгийн 203 иргэн хамрагдав. |
| 4 сар | Нийгмийн ажилтнуудын уулзалт | - 6 дүүргийн 35 нийгмийн ажилтан оролцов. |
| 5 сар | Өрхийн хөгжлийг дэмжих аян | - 2 дүүргийн 10 өрх оролцов. |
| 6-8 сар | Иргэдийн бүлгийн холбоодын уралдаан | - Хан-уул, Сонгинохайрхан, Баян-гол, Баян-зүрх, Сүхбаатар дүүргүүдийн иргэдийн холбоодын 64 иргэн оролцов. |
| 5-9 сар | Хог цэвэрлэгээ | - 526 хүн нийт 38 байршилд нийтийн цэвэрлэгээ хийсэн. |
| 9-10 сар | Олон нийтийн хөгжил үзэсгэлэн, өдөрлөг | - 1000 орчим хүн өдөрлөгт оролцов. |
| 9-10 сар | Төслийн олон нийттэй ажиллах арга зүйн гарын авлага бэлтгэх | - 300 хувийг хэвлэн иргэдийн бүлгүүд, ижил төстэй төслүүд, их сургуулиудад тараав. |
| 11-12 сар | Төслийн нөлөөллийн судалгаа | - Судалгаанд 344 иргэнийг хамруулав. |

БҮЛЭГ II. ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ДЭМЖИХ ХОЁР ДАХЬ ТӨСӨЛ

| Хугацаа | Ажил | Тайлбар |
|----------|-----------------------------------------|-----------------------------------|
| 12 сар | Жүжигчилсэн тоглолт | - Бүрэн биелэв. |
| 3-р сар | Нэгдүгээр улиралын бүлгүүдийн үнэлгээ | - 27 бүлгийн 74 гишүүн хамрагдав. |
| 6-р сар | Хоёрдугаар улиралын бүлгүүдийн үнэлгээ | - 24 бүлгийн 64 гишүүн хамрагдав. |
| 9-р сар | Гуравдугаар улиралын бүлгүүдийн үнэлгээ | - 23 бүлгийн 60 гишүүн хамрагдав. |
| 12-р сар | Дөрөвдүгээр улиралын бүлгүүдийн үнэлгээ | - Явцтай |

2.3 ОЛОН НИЙТИЙН ХӨГЖИЛ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Төслийг удирдах нэгж нь олон нийтийн хөгжлийг дэмжих чиглэлээр 2012 онд дараахи зорилтуудыг дэвшүүлэн ажилласан.

- а. Чадавхийг бэхжүүлэх: Гэр хорооллын иргэд, олон нийтэд мэдээллийг хүртээмжтэй болгох, иргэдийг сургах
- б. Олон нийтийн зохион байгуулалтыг боловсронгуй болгох: иргэдийн төлөөллийн бүлгүүдийн хамтын ажиллагаа, харилцаа холбоо, удирдлага зохион байгуулалт, эв нэгдлийг бэхжүүлэх
- с. Харилцаа холбоог хөгжүүлэх: иргэдийн бүлгүүдийг сурталчлах, холбогдох байгууллага, мэргэжилтнүүдтэй холбон зуучлах зэрэг болно.

2.3.1 Чадавхийг бэхжүүлэх нь



Зураг 2.

Бэлтгэл бүлгийн сургалт

Иргэдийн үүсгэл санаачлагын бүлгийн мөн чанар, хэрэгцээ, ач холбогдол, бүлэгт нэгдэх, бусадтай хамрах арга зам, боломжууд зэрэг сэдвүүдээр 28 цагийн багц бэлтгэн, сургалтыг зохион байгуулав. Сургалтын идэвхитэй аргууд болох бүлгийн ажил, дүр тоглолт, тоглоом, кейс хэлэлцүүлэг зэргийг ашигласан нь оролцооны мөн чанарыг иргэдэд ойлгуулах давуу талтай байсан.


Ахлах бүлгийн сургалт



Зураг 3.

Бүлгийн тогтвортой байдал, бусдад нөлөөлөх арга, шийдвэр гаргах үйл явц зэрэг сэдвүүдийг багтаасан 24 цагийн багцыг бэлтгэн сургалтыг зохион байгуулав. Ахлах бүлгүүдийн хэрэгцээ, мэдлэг, туршлагад тулгуурлан (i) эргэцүүлэх, (ii) дүгнэх, (iii) харьцуулах, (iv) хэлэлцэх, (v) нөлөөлөх, (vi) илэрхийлэх, (vii) тайлагнах даалгаваруудыг гүйцэтгэх, эргэх холбоогоор харилцан бие биенээ үнэлэн дүгнэх зарчмаар сургалтыг зохион байгуулсан.

БҮЛЭГ II. ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ДЭМЖИХ ХОЁР ДАХЬ ТӨСӨЛ



Зураг 4.

Өрхийн хөгжил аян

Гэр бүлийн өмнө тулгарч буй аливаа асуудлыг дотроо хэлэлцэх, гарцыг хамтдаа эрэлхийлэх, нэг зорилгын төлөө бүх гишүүд хүчин зүтгэх буюу өөрсдийн нөөц боломжинд тулгуурлан өрх гэрээ хөгжүүлэх арга замуудын талаар иргэд мэдээлэл солилцон, сэтгэл зүйчээс зөвлөгөө авсан. Өрх гэрийн хөгжил нь харилцаа, ойлголцол, итгэлцэл, хүндэтгэлээс эхлэнэ гэсэн гол мэдээллийг өрхүүдэд хүргэв.

Бүлгийн үнэлгээ



Зураг 5.

Иргэдийн бүлгүүдийн хөгжил төлөвшил, ололт амжилт, алдаа дутагдлыг улирал бүрт үнэлэн дүгнэх ажлыг төслийн зохицуулагчид гүйцэтгэдэг. Үнэлгээ нь (i) гүйцэтгэгч бүлгүүдийг сонгон шалгаруулах, (ii) бүлгийн хөгжил төлөвшилтэй уялдуулан сургалт, зөвлөгөө мэдээлэл өгөх ажлыг төлөвлөн зохион байгуулах, (iii) эргэх холбоог иргэдтэй тогтмол хадгалах зэрэг олон давуу талтай. Улирал тутамд үнэлэх нь бүлгийн гишүүдийн хариуцлага, тогтвортой байдалд эерэгээр нөлөөлж байна.

2.3.2 Олон нийтийн зохион байгуулалт



Зураг 6.

Зөвлөлдөх уулзалт

Төслийн хоёр дахь шатны онцлог, үйл ажиллагааны гарын авлагын талаар мэдээллийг хүргэж, салангид ажиллаж буй иргэдийн бүлгүүдийг харьяа дүүргийн холбоонд нь нэгтгэх, холбоо бүр 2012 оны зорилт, төлөвлөгөөгөө боловсруулах ажлыг зохион байгуулав. Төслийн өмнөх шатанд иргэд зөвхөн бүлгийн төлөвлөгөөг боловсруулдаг байсан бол энэ жилээс эхлэн холбооны зохион байгуулалтанд орж, дүүргийн хэмжээнд ажилласан нь онцлог байв.



Зураг 7.

Холбоодын уралдаан

Зөвлөлдөх уулзалтаар боловсруулсан холбоо бүрийн зорилт, төлөвлөгөөний биелэлтийг хэлэлцэн, үнэлэн дүгнэв. Холбоо бүр хагас жилийн тайлангаа танилцуулж, харилцан бие биенээ тойргийн журмаар үнэлэх замаар "шилдэг" холбоог шалгаруулсан. Төлөвлөгөөний биелэлт хангалтгүй байгаа холбоод үлдсэн хугацаанд дахин төлөвлөгөө боловсруулах 2012 оны 12-р сард эргэн тайлагнах үүргийг хүлээв.

БҮЛЭГ II. ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ДЭМЖИХ ХОЁР ДАХЬ ТӨСӨЛ

Нийтийн хамарсан хог цэвэрлэгээ



Зураг 8.

Гэр хорооллын орчин дахь нийтийн эзэмшлийн талбай болох сургууль, цэцэрлэг, эмнэлэгийн эргэн тойрон, гудамж, автобусны буудал зэрэг хөл хөдөлгөөн ихтэй 38 цэгийг сонгон холбоо бүр нийтийн цэвэрлэгээг зохион байгуулав. Нийтийн цэвэрлэгээнд оршин суугчид, залуучуудын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор сургуулиудтай хамтран ажилласан нь үр дүн сайтай болсон. Нийтийг хамарсан цэвэрлэгээний ажлыг хэрхэн зохион байгуулсан болон гол үр дүнг нэгтгэн дүгнэж нийслэлийн холбогдох хэлтэст тайланг хүргүүлсэн.

2.3.3 Хамтын ажиллагаа, харилцаа холбоо



Зураг 9.

Үзэсгэлэн

Иргэдийн бүлгүүдийн үйл ажиллагааг сурталчлах, орлогыг нэмэгдүүлэх зорилгоор “Олон нийтийн хөгжил” нээлттэй өдөрлөг, үзэсгэлэнг зохион байгуулсан. Арга хэмжээний үеэр олон нийтийн хөгжил илтгэл танилцуулга, үзэсгэлэн, худалдаа, зөвлөгөө, санал хүсэлтийн буланг ажиллуулсан. Иргэдийн бүтээлүүдийг дэлгэн сурталчилж, 131 төрлийн 500 бүтээгдэхүүнийг худалдаанд гаргаж 1,7 сая төгрөгийн борлуулалт хийв.



“Хөгжлийн хэмнэл” арга зүйн гарын авлага

Зураг 10.

Иргэдийн оролцоог дэмжих арга зүй, үзэл баримтлалын талаархи өөрсдийн туршлага сургамжаа эмхэтгэн “Хөгжлийн хэмнэл” гарын авлагыг бэлтгэн хэвлэв. Гарын авлагыг нийгмийн ажилтан бэлтгэж буй Монгол улсын их сургууль, Боловсролын их сургууль, Шинжлэх ухаан технологийн их сургуулийн нийгмийн ажлын тэнхим болон иргэд, нийслэлийн төр захиргааны байгууллагын 300 хүнд хүргэсэн.



Зураг 11.

Жүжигчилсэн тоглолт

Холбоод хамтран иргэдийн оролцооны мөн чанар, онцлогийг харуулах зорилготой 30 минутын жүжигчилсэн тоглолтын зохиолыг бэлтгэн, найруулж гэр хорооллын иргэд болон хорооны нийгмийн ажилтнуудад тоглолтоо хүргэхээр төлөвлөж байна. Иргэд иргэдээ сургах, боловсролын ялгаатай байдлаас үл хамааран мэдээллийг оновчтой арга замаар хүргэж буй нийгмийн жүжиг нь нэг талаар соёлын арга хэмжээ болохын зэрэгцээ олон хүмүүст нөлөөлөх нилээд өвөрмөц шийдэл юм.

БҮЛЭГ II. ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ДЭМЖИХ ХОЁР ДАХЬ ТӨСӨЛ



Зураг 12.

Нийгмийн ажилтнуудын уулзалт

Иргэдийн бүлгүүдийг дэмжиж хамтран ажиллах хэрэгцээ, ач холбогдлыг ойлгуулах, гэр хороололд өрнөж буй иргэдийн оролцоог дэмжих энгийн арга замуудын талаар хороодын нийгмийн ажилтнуудтай хэлэлцэн мэдээлэл хуваалцав. Бүлгүүдийн байршил, хаяг, холбоодын онцлог, хуримтлуулсан туршлага зэргийг нийгмийн ажилтнуудад мэдээлж, иргэдийн оролцоог тогтвортой дэмжих чиглэлээр хорооны түвшинд зохион байгуулж болох ажил, санаачлагуудыг оролцогчид хамтдаа жагсаав.

2.3.4 Үр шим хүртэгсдийн тоо

Хүснэгт 3. Үр шим хүртэгсэд ба сэтгэл ханамжийн үнэлгээ

| Үзүүлэлт | Үр дүн |
|-------------------------------------------------|--------------------------------------------------|
| Арга хэмжээнүүдэд хамрагдсан оролцогчдын тоо | 2988, 100% |
| Оролцогчдоос тогтвортой ажиллаж буй хувь хэмжээ | 500 орчим иргэн |
| Сэтгэл ханамжийн судалгаа ¹ | 87% - сайн 9% - дунд зэрэг 4% - хангалтгүй |

2.3.5 Хүндрэл бэрхшээл, сургамж

1. Нөөц боломжиндоо тулгуурлан өөртөө туслах зорилгоор аливаа санал, санаачлагыг хэрэгжүүлж тогтвортой ажиллахад нь иргэдийн бүлгүүдэд (i) хүн хүчний нөөц, тэдний чадамж, (ii) өөрөө өөрийгөө санхүүжүүлэхэд чиглэгдсэн бичил бизнес, эдийн засгийн эх үүсвэр хамгаас чухал юм. Төслийн зүгээс дээрхи хоёр чиглэлээр тодорхой хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж байгаа хэдий ч төр захиргааны байгууллагуудын дэмжлэг, зохицуулалт үгүйлэгдэж байна. Бүлгүүд гэр ахуй, гоёл чимэглэл, хувцас, модон эдлэл, хүнсний ногоо зэрэг тодорхой төрлийн бараа бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрлэдэг хэдий ч тэдгээрийг зах зээлтэй холбох тогтвортой механизм байхгүй байна.
2. Нийслэлийн гэр хорооллын иргэдийн оролцоо, хамтын ажиллагааг цөөн хэдэн төслүүдээр бүрэн төгс хөгжүүлэх боломжгүй. Иймээс төрийн болон иргэний нийгмийн, хөгжлийн байгууллагуудын хамтын ажиллагааг дэмжих, нэгтгэн зангидах бодлого, зохицуулалт хамгаас чухал юм. Төсөл, хөтөлбөрүүд, олон улсын байгууллагууд иргэдийн оролцоог дэмжих чиглэлээр тодорхой санаачлагуудыг нэвтрүүлж байгаа хэдий ч тэдгээрийг нэгтгэн зангидах, тогтвортой байдлыг хангах, дэмжих систем, бүтэц төрийн байгууллагад байхгүй байна. Хороо, дүүрэг, нийслэлийн төр захиргааны байгууллагуудын албан үүрэг тодорхой бус, хоорондоо зааг ялгаа багатай, давхардалт ихтэй байгаа нь олон нийтийн оролцоог дэмжих ажил үүргийг эзэнгүйдүүлэхэд хүргэж байна.

¹Сэтгэл ханамжийн судалгааг арга хэмжээ бүрийн дараа авч баримтжуулдаг.

3. Холбоодын төлөвлөсөн, хэрэгжүүлсэн ажлуудыг харахад зөвхөн гишүүддээ, дотооддоо чиглэгдсэн болох нь ажиглагдаж байна. Энэ нь нэг талаар холбооны зохион байгуулалтанд орж буй эхэн шатны онцлог байж болох хэдий ч төслийн нийгмийн нөлөөллийг нэмэгдүүлэхийн тулд үйл ажиллагаагаа илүү өргөн хүрээнд харах, төлөвлөх хэрэгцээ холбоодын өмнө тулгарч байна.

2.4 БАРИЛГЫН АЖИЛ, ТЕХНИКИЙН АСУУДЛУУД

2.4.1 Барилгын ажлын үйл явц

Төслийн хүрээнд нийт 39 барилгын ажлыг гүйцэтгэхээр 2012 онд төлөвлөсөн. Тэдгээрээс хяналтын камер, хогийн цэг, нийтийн бие засах газар зэрэг ажлуудыг Нийслэлийн цагдаагийн газрын хүсэлт, ариун цэвэр, хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр хотоос мөрдөж буй бодлого, шинэчлэлтэй уялдан хэрэгжүүлэхгүй байх шийдвэрийг гаргасан. Барилгын ажлын үйл явцыг худалдан авах ажиллагааны хэсэгт хүснэгтээр үзүүлсэн болно.

2.4.2 Барилгын ажилд тавигдсан хяналт, үнэлгээ

1. Иргэдийн хяналт: Тэтгэвэрт гарсан барилгын инженерүүдээс бүрдсэн гэр хорооллын иргэдийн хяналтын бүлгийг байгуулж, иргэдийн оролцоотой гүйцэтгэж буй барилгын ажилд өдөр тутмын хяналт, зөвлөгөөг өгч ажилласан. Хяналтын багийн ажлын журам болон хяналтын үйл явцыг баримтжуулах гарын авлага, зааврыг ТУН-ээс боловсруулан сургасан. Иргэдийн хяналтын баг нь хяналт тавихаас гадна бүлгүүдийг үзүүлэн сургалтаар чадваржуулах, шилдэг гүйцэтгэлийг шалгаруулан бусад бүлгүүдэд сурталчлах ажлыг санаачлан хэрэгжүүлсэн. 2012 оны барилгын ажилд тавьсан иргэдийн хяналтын холбогдох тайланг баримтжуулан хадгалж байна. Энэхүү баг нь иргэдийн бүлгүүдийн гүйцэтгэсэн 35 барилгын ажилд 2205 хүн өдөр хяналт тавьсан. Хяналтын үр дүнд чанарын шаардлага хангаагүй 4 барилгын ажлыг зогсоож, цутгасан замыг хуулан өдөр тутмын хяналтын доор дахин шинээр гүйцэтгэсэн.
2. ТУН-ийн хяналт: 2 төрлийн хяналт тавьж ирлээ. А: Мэргэжлийн компаниудын хийж гүйцэтгэсэн ажилд Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар, Улаанбаатар сангийн зүгээс захиалагчийн хяналтыг, Б:Төслийг удирдах нэгжийн техникийн хяналтыг инженер Д.Нямдорж, нярав Л.Мөрөндалай, зохицуулагч О.Хулан нар долоо хоног тутмын хяналт тавьж, 14 хоног тутамд техникийн асуудлаар гүйцэтгэгч, зохиогчтой хамтарсан хурлыг зохион байгуулсан. Зарим техникийн хүндрэлтэй асуудлуудыг (цахилгаан, газар) газар дээр нь холбогдох талуудыг оролцуулан шийдэж байсан. ТУН-ийн хяналтын баг нь 41 барилгын ажилд 512 хүн өдөр хяналт тавьсан. Хяналтын явцад 35 барилгын ажлын гүйцэтгэлд анхааруулга, заавар өгч, гүйцэтгэлийг чанарыг сайжруулахад дэмжлэг үзүүлсэн.
3. Хяналтын багийн хяналт: Дэлхийн банкны хяналтын баг 2012 оны 10-р сарын 23 нд үерийн далан, сити тойлет, тоглоомын талбай, хүүхэд хөгжлийн төв зэрэг 4 объектод нийт 30 хүн цагийн хяналт тавьсан. Хяналтын үр дүнд Сити тойлетийн дотор ханын өрлөгийг буулгаж дахин өрсөн. Хяналтын дүнд

БҮЛЭГ II. ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ДЭМЖИХ ХОЁР ДАХЬ ТӨСӨЛ

тодорхой хугацаатай үүргийг өгч, биелэлтийг 2012 оны 11-р сард шалгаж санхүүжилтийг шийдсэн.

4. Дотоодын хяналт: ТУН-ийн захирал, нягтлан, менежер, инженер, гэрээний мэргэжилтэн, нярав, иргэдийн 3 бүлгийн төлөөлөл, гүйцэтгэгчдээс бүрдсэн дотоодын хяналтын багийг байгуулж 2012 оны 10-р сард мэргэжлийн байгууллагуудын гүйцэтгэж буй 3 объектод 60 хүн цагийн хяналт тавьсан.
5. Захиалагчийн хяналт: Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар, Улаанбаатар сангаас 3 мэргэжлийн байгууллагын гүйцэтгэж буй 3 объектод ойролцоогоор 120 орчим хүн цагийн хяналт тавьсан.



Зураг 13. Сити тойлет нийтийн бие засах газар



Зураг 14. ЧД-ийн 18-р хороо, Долоон буудлын эцэст "City toilet" Нийтийн бие засах газрын нээлийн үеэр. 2012 оны 12-р сарын 28



Зураг 15. Явган гүүр



Зураг 16. Хүүхэд залуучуудын хөгжлийн төв

2.4.3 Үр шим хүртэгчдийн тоо

Хүснэгт 4. Үр шим хүртэгчдийн тоо

| N° | Дэд бүтэц | Ашиглаж буй хүний тоо |
|----|------------------------------|-----------------------|
| 1 | Явган хүний гүүр | 900 |
| 2 | Гүний худаг | 1125 |
| 3 | Явган зам | 14970 |
| 4 | Тоглоомын талбай | 150 |
| 5 | Усны эх үүсвэрийн хамгаалалт | 30 |
| 6 | Нийт | 17175 ² |

²Дэд бүтцийн орчны 500 м-ийн радиусд оршин сууж буй иргэдийн тоо, нийгмийн үйлчилгээний байгууллагатай холбож буй төв гудамжинд тавигдсан явган замын хувьд нэг өдөрт дундажаар үйлчлүүлж буй иргэний тоог ирэх, очих 2 чиглэлд тооцон статистик үнэлгээг хийв.

БҮЛЭГ II. ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ДЭМЖИХ ХОЁР ДАХЬ ТӨСӨЛ

2.4.4 Хүндрэл бэрхшээл, сургамж

- Гүйцэтгэгч байгууллагуудын ур чадвар, хариуцлагыг нэмэгдүүлэх шаардлагатай. Барилгын ажлын гүйцэтгэлийн графикийг боловсруулах чадварт сургах, энэ чиглэлээр тэдэнд мэдээлэл, зөвлөгөө өгөх хэрэгцээ ажиглагдав. Барилгын ажлын явцын тэмдэглэл, талбайн журналын хөтлөлтийг сайжруулах чиглэлээр хялбаршуулсан зөвлөмж, сургалтыг зохион байгуулах нь үр дүнтэй юм.
- Захиалагчийн хариуцлагыг нэмэгдүүлэх, гэрээнд тэдний гүйцэтгэх үүргийг хэмжигдэхүйц байдлаар тодорхой оруулах нь зүйтэй гэж үзэж байна.
- ТҮН-ийн машин хүрэлцээ муу байсан нь барилгын хяналтыг тогтмол тавихад хүндрэл учруулж, ажилтнууд хувийн машин, зардлаараа барилгын талбайд очих зэрэг хүндрэлтэй асуудлууд тулгарч байсан.

2.5 ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА

2.5.1 Танилцуулга

Төслийн хүрээнд хийгдсэн худалдан авах ажиллагааг Танилцуулга, үндэслэл, төлөвлөлт; ХАА-ны явц, гарсан үр дүн, үр нөлөө, сургамж гэсэн үндсэн хэсгүүдээр тайлагнаж байна. Төсөл хэрэгжилтийн явцад хөтөлсөн худалдан авах ажиллагааны бүртгэлд дүн шинжилгээ хийж, үр дүнг дүгнэн оруулсан болно.

Худалдан авах ажиллагааны хүрээнд нийтдээ 28 гэрээт ажлын асуудлыг шийдвэрлэв.

Худалдан авах ажиллагааны явцад дараахи үндсэн зарчмыг баримталсан:

- Сонгон шалгаруулалтад оролцох эрхтэй оролцогсад ижил эрхтэй байх,
- Нээлттэй байх зарчмуудыг баримтлав.

2.5.2 Төлөвлөлт

Төслийн хүрээнд хэрэгжих гэрээт ажил бүрийн үнэлгээний арга, хяналтын хэлбэрийг ХАА-ны төлөвлөгөө (Хавсралт 1)-нд тусгаж, хэрэгжих хугацааг ХАА-ны үе шат бүрээр гарган Төслийг удирдах хороо (ТҮХ), Дэлхийн банкаар баталгаажуулан ажиллалаа.

2012 онд төслийн ХАА-ны хүрээнд дараахи гэрээт ажлуудыг төлөвлөв.

Хүснэгт 5. Төслийн 2012 оны ХАА-ны төлөвлөгөөний хураангуй

| Зардлын ангилал | Мэргэжлийн байгууллагын гүйцэтгэх | Иргэдийн оролцоотой хэрэгжүүлэх | Зөвлөхийн гүйцэтгэх | Нийт |
|-------------------------|-----------------------------------|---------------------------------|---------------------|------|
| Барилгын ажил | 5 | 24 | | 29 |
| Бараа ханган нийлүүлэлт | 1 | | | 1 |
| Үйлчилгээ | | | 3 | 3 |
| Дүн | 6 | 24 | 3 | 33 |

БҮЛЭГ II. ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ДЭМЖИХ ХОЁР ДАХЬ ТӨСӨЛ

Хүснэгт 6.2012 онд төлөвлөсөн гэрээт ажлын биелэлт

| № | Гэрээний нэр, дугаар | Гэрээт үнэ (сая төг) | Гүйцэтгэгч | Биелэлт |
|--------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------|--------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| А Мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх гэрээт ажлууд | | | | |
| 1 | Сонгинохайрхан дүүргийн 9 дүгээр хорооны Баруун Баян Уулын 0.4 км урттай үерийн хамгаалалтын далан суваг барих ажил, P1-DR | 195.7 | Монинжбар ХК | Барилгын ажил дуусч, 2012 оны 11-р сарын 27-нд Техникийн комисс хүлээн авсан. |
| 2 | Чингэлтэй дүүргийн 16-р хороо, Сонгинохайрхан дүүргийн 24-р хорооны 12 м урт, төмөр бетон хоёр явган гүүр барих ажил, P1-FB | 56.7 | ЗМЗ ХХК | Барилгын ажил 2012 оны 8-р сарын 1-нд дууссан. |
| 3 | Чингэлтэй дүүргийн 18-р хорооны "Сити тойлет" нийтийн бие засах газар барих ажил, P2-CT | 129.8 | Санжат ХХК | Улсын комисст хүлээлгэн өгсөн. |
| 4 | Сүхбаатар дүүргийн 20-р хороонд гүний худаг ерөмдөх, гүний худгийн барилга барих ажил, P2-BO | 16.8 | Акваган ХХК | Барилгын ажил 2012 оны 11-р сарын 24-нд дууссан. |
| Б Иргэдийн оролцоотой гүйцэтгэх гэрээт ажлууд | | | | |
| 1 | БГД-ийн 23-р хороо, ХҮД-ийн 4-р хороонд 350м урт явган зам барих ажил | 30.8 | Иргэдийн 2 бүлэг | Барилгын ажил төлөвлөсөн хугацаандаа дууссан. |
| 2 | БЗД-ийн 27-р хороо, СБД-ийн 16-р хороо, БГД-ийн 23-р хороо, ХҮД-ийн 8-р хороо, СХД-ийн 24-р хороо, ЧД-ийн 19-р хороонд сагсны 7талбай барих ажил | 106.2 | Иргэдийн 8 бүлэг | Барилгын ажил төлөвлөсөн хугацаандаа дууссан. |
| 3 | БЗД-ийн 21-р хороонд 0.4 км урт үерийн ус зайлуулах суваг барих ажил, C1-PW-BZ21A - C1-PW-BZ21F | 59.0 | Иргэдийн 6 бүлэг | Ажлын гүйцэтгэл 95 хувьд хүрээд байхад 2012 оны 6-р сарын 19-нд орсон аадар борооны улмаас үер болж, сувгийн бэхжиж амжаагүй байсан бэхэлгээг урсгасан. |
| 4 | Иргэдийн бүлгийн оролцоот барилгын ажлын хяналт хийх | 6.5 | Монголын ахмад, зөвлөх мэргэжилтэ нүүдийн холбоо | Барилгын ажлын явцад хяналт тавьж, ажилласан, гэрээт ажлууд дуусгавар болсон. |

БҮЛЭГ II. ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ДЭМЖИХ ХОЁР ДАХЬ ТӨСӨЛ

| № | Гэрээний нэр, дугаар | Гэрээт үнэ (сая төг) | Гүйцэтгэгч | Биелэлт |
|---|---------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------|--------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| В | Зөвлөхийн үйлчилгээ | | | |
| 1 | Мэргэжлийн байгууллагын гүйцэтгэх барилга байгууламжийн зураг төсөл боловсруулж, төсөвт өртгийг тооцоолох, T5-DN | 21.9 | Эм Даблюу Ти ХХК, Ялгуусан ХХК-ийн түншлэл | Үерийн далангийн зураг төслийг хугацаанд нь боловсруулж дууссан. Авто замын зураг төсөл боловсруулах ажил гүйцэтгэгчийн буруугаас хугацаа хоцорсон. |
| 2 | Иргэдийн оролцоотой барих бичил дэд бүтцийн байгууламжийн зураг төсөл боловсруулах, төсөвт өртгийг тооцоолох, T5-DC | 6.8 | Бие даасан зөвлөх Л.Золжаргал | Гэрээт ажил хугацаандаа биелсэн. |
| 3 | Дүүргийн төлөвлөлт ба байгууллагын чадавхийг бэхжүүлэхэд үзүүлэх техникийн туслалцаа | Төсөвт өртөг: 0.314 сая ам.доллар | | Гэрээт ажлын сонгон шалгаруулалт явагдаж байна. |

2.5.3 Сонгон шалгаруулалтын бэлтгэл ажлууд

ХАА-ны үе шат

- *Сонгон шалгаруулалтын баримт бичиг (СШББ) боловсруулах* –Төсөл хэрэгжилтийн явцад барилга ажлын дотоодын нээлттэй сонгон шалгаруулалтын 2, харьцуулалтын аргын 2, зөвлөхийн үйлчилгээний 2 баримт бичгийг боловсруулсан.

Зарлал – Сонгон шалгаруулалтыг нээлттэй, өрсөлдөөнтэй байлгахад сонгон шалгаруулалтын зар чухал тул барилгын ажлын дотоодын сонгон шалгаруулалтын зарыг өдөр тутмын хэвлэл (Өдрийн сонин, Өнөөдөр), Засгийн газрын ХАА-ны www.e-procurement.mn сайт, төслийн www.usip2.mn сайтаар тогтмол хүргүүлсэн. Зөвлөхийн олон улсын сонгон шалгаруулалтыг дээрх хэвлэл, сайтаас гадна олон улсын сонгон шалгаруулалтын UNDB, dgmarket сайт дээр нийтлүүлсэн. Мөн тухайн ажил, үйлчилгээтэй ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага, компаниудад зарыг факсаар болон электрон шуудангаар илгээсэн.

- *Сонгон шалгаруулалтыг нээлт* – 2 сонгон шалгаруулалтын нээлтийг санал ирүүлэх эцсийн өдөр, цагт оролцогсдыг байлцуулан нээж, үнийн санал, банкны баталгааг нийтэд зарласан.
- *Үнэлгээ хийх, Үнэлгээний хороо байгуулах* - Барилгын ажлын дотоодын нээлттэй 2 сонгон шалгаруулалт, зөвлөхийн 1 гэрээт ажлын үнэлгээг хийх 3 үнэлгээний хороо байгуулсан. Үнэлгээний хорооны гишүүд ирсэн саналуудыг хянаж, үнэлгээ хийх зав цаг муу байдаг учраас ТҮН-аас уг хороонд орсон

БҮЛЭГ II. ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ДЭМЖИХ ХОЁР ДАХЬ ТӨСӨЛ

ажилтнууд саналуудыг хянан холбогдох мэдээллийг бүрдүүлэн Үнэлгээний хорооны гишүүдэд танилцуулж, олонхийн саналаар гэрээт ажлыг гүйцэтгэгчийг шалгаруулан Дэлхийн банкнаас зөвшөөрөл авсан.

Хүснэгт 7. Үнэлгээний хорооны мэдээлэл

| № | Гэрээний нэр | Тайлбар |
|---|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1 | Сонгинохайрхан дүүргийн 9 дүгээр хорооны Баруун Баян Уулын үерийн хамгаалалтын далан суваг барих ажил | НЗД-ын 2012-7-21-ний өдрийн А/508 тоот захирамжаар Улаанбаатар хотын Ерөнхий менежер, Захирагчийн ажлын албаны даргаар ахлуулсан 7 гишүүнтэй Үнэлгээний хороо байгуулсан. |
| 2 | Чингэлтэй дүүргийн 18-р хорооны "Сити тойлет" нийтийн бие засах газар барих ажил | НЗД-ын 2012-5-4-ний өдрийн А/307 тоот захирамжаар Улаанбаатар хотын Ерөнхий менежер, Захирагчийн ажлын албаны даргаар ахлуулсан 7 гишүүнтэй Үнэлгээний хороо байгуулсан. |
| 3 | Нийслэлийн дүүргүүдийн төлөвлөлтийн асуудлыг боловсронгуй болгож, дүүргийн ажилтнуудыг чадавхижуулах техникийн туслалцаа үзүүлэх | НЗД-ын 2012-05-4-ний өдрийн А/308 тоот захирамжаар Улаанбаатар хотын Ерөнхий менежер, Захирагчийн ажлын албаны даргаар ахлуулсан 7 гишүүнтэй Үнэлгээний хороо байгуулсан. |

- *Гэрээ байгуулах* - Тайлангийн хугацаанд нийтдээ 28 гэрээ байгуулсан.
- *Гэрээний хэрэгжилт* – Төслийн бүхий л гэрээний хэрэгжилтэд ТҮН-ийн инженерүүд, ЯНХС-гийн зохицуулагч нар хяналт тавьдаг. Гэрээт ажлын хэрэгжилтийн хугацаанд хийсэн дүн шинжилгээг дараахи бүлгээс үзнэ үү.
- *Иргэдийн оролцоот гэрээт ажлуудын ХАА-ны онцлог* - Тус төслийн хувьд иргэдийн оролцоонд тулгуурлан хэрэгжүүлсэн бичил төслүүдийн гэрээт ажлуудын ХАА нь онцлог бөгөөд төслийн хэрэгжүүлэх явцад бий болсон туршлага, ололт, сул талуудыг үнэлэн улс орны туршлагыг үндэслэн иргэдийн оролцоот гэрээт ажлуудыг зохион байгуулах өөрийн гэсэн арга, аргачлалтай болсон.

Иргэдийн зохион байгуулалт, бичил дэд төслүүдийн сонголт, явц, хяналт зэргийг энэхүү тайлангийн бусад бүлгүүдэд тодорхой тусгасан тул энд зөвхөн уг гэрээт ажлуудын ХАА-ны онцлогийг дурдлаа:

- a. Иргэдийн бүлгүүдийн гүйцэтгэх ажлын зарыг төслийн вэб хуудсаар дамжуулан иргэдийн бүлгүүдэд хүргэдэг.
- b. Зарын дагуу уг ажлыг гүйцэтгэх хүсэлтээ иргэдийн бүлгүүд ТҮН-д хүргүүлдэг. Тухайн ажлыг гүйцэтгэх иргэдийн бүлгийн дүүрэг, хорооны харьяалал, гүйцэтгэх ажлын байрлалаас үл хамааран аль ч дүүргийн иргэдийн бүлэг зарласан ажлыг гүйцэтгэх хүсэлтээ ирүүлж болно.
- c. Ирсэн хүсэлтүүдийг хянан үзээд иргэдийн бүлгүүдэд ажил хуваарилахдаа дараахи шалгуур үзүүлэлтүүдийг харгалзан үзсэн:
 - Иргэдийн санаачилсан олон нийтийн ажлуудад оролцсон идэвхийг дараахи үзүүлэлтээр үнэлдэг:

БҮЛЭГ II. ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ДЭМЖИХ ХОЁР ДАХЬ ТӨСӨЛ

- Иргэдийн бүлгийн өөрсдийн идэвх санаачилга
- Төслийн хүрээнд зохион байгуулсан ажлуудад оролцсон байдал
- Иргэдийн бүлгүүдийн холбооноос зохион байгуулсан ажлуудад оролцсон байдал
- Бүлэгтээ шинэ гишүүдийг элсүүлсэн буюу шинэ иргэдийн бүлэг бүрэлдэхэд нөлөөлсөн байдал
- Иргэдийн бүлгийн хуримтлалын сангийн бүрдэлт, ашиглалт, тогтвортой байдал
- Бүлгийн чадавхи, ур чадвар сайжирсан байдал
- Өмнө авсан дэд төслийн ажлын гүйцэтгэл, арчлалт хамгаалалт

Дээрх үзүүлэлтээрээ шалгарсан иргэдийн бүлэгт зарласан ажлыг гүйцэтгэх эрхийг олгодог.

d. Иргэдийн бүлгүүдтэй хийдэг гэрээний маягтыг 2011 онд Дэлхийн банкаар баталгаажуулсан бөгөөд уг гэрээг дэд бүтцийн бүх ажлуудад е. ашиглаж байна. Харин уг гэрээний салшгүй хэсэг болох ажлын тодорхойлолт, ажлын тоо хэмжээг зураг төсөл хийсэн зөвлөх боловсруулж, ТУН-ийн үйл ажиллагааны менежер хянасны дараа гэрээний баримт бичигт оруулдаг. Ажил гүйцэтгэх хуваарийг гүйцэтгэгч талтай тохиролцон зөвшилцдөг.

f. Иргэдийн бүлгүүдтэй хийх гэрээний гүйцэтгэлийн баталгааг хангах үүднээс ажил гүйцэтгэгч бүлгийн ахлагч өөрийн эзэмшилд байгаа үр хөдлөх хөрөнгийн гэрчилгээний эх хувийг гэрээ байгуулахаас өмнө ТУН-ийн ня-бод албан ёсоор баталгаа болгон үлдээж, ажлаа дууссны дараа буцааж авдаг.

2.5.4 Гэрээт ажлын хэрэгжилт

Гэрээт ажлын хэрэгжилтийн хугацааг барилга угсралтын ажлын жишээ нь дээр үнэлгээ хийж, төлөвлөлттэй харьцуулан үзэхэд үерийн хамгаалалтын далан суваг барих ажлыг эхлэх зөвшөөрөл олгох асуудал хугацаа хоцорсноос гэрээт ажил төлөвлөсөн хугацаанаас 20 гаруй хоног хоцорсон байна.

Явган гүүр барих, худаг гаргах ажлууд хэдийгээр цар хэмжээний хувьд бага ажил байсан ч уг гэрээт ажлуудын гүйцэтгэгч ЗМЗ ХХК болон Акваган ХХК сайн ажиллаж, гэрээт ажлыг хугацаанд нь сайн гүйцэтгэсэн.

Мэргэжлийн байгууллагын гүйцэтгэх барилга байгууламжийн зураг төсөл боловсруулж, төсөвт өртгийг тооцоолох ажлыг Эм Даблю Ти ХХК, Ялгуусан ХХК-ийн түншлэл гүйцэтгэсэн бөгөөд Эм Даблю Ти ХХК хариуцсан ажлаа хугацаандаа хийв. Экспертиз томилогдоогүйн улмаас Ялгуусан ХХК авто зам барих зураг төсөл хугацаандаа хийгдээгүй. 2012 онд төлөвлөж байсан авто замын барилгын ажлыг ирэх онд эхлүүлэхээр болж байна.

Иргэдийн оролцоотой хийгдсэн ажлууд бүгд хугацаандаа хэрэгжсэн.

2.5.5 Сургалт

Тайлант хугацаанд Дэлхийн банкнаас зохион байгуулсан худалдан авах ажиллагааны журмын шинэчлэлтэй холбогдсон сургалтад төслийн худалдан авах ажиллагааны ажлтанууд хамрагдаж, зохих мэдлэгтэй боллоо. Мөн СЯ-ны ХАА-ны

БҮЛЭГ II. ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ДЭМЖИХ ХОЁР ДАХЬ ТӨСӨЛ

газраас зохион байгуулсан худалдан авах ажиллагааны сургалтад ТҮН-ын ажилтнууд хамрагдан гэрчилгээ авсан.

2.5.6 Хяналт

ХАА-ны явцад Дэлхийн банкнаас тогтмол хяналт тавьдаг бөгөөд ХАА-ны мэргэжилтэн төслийн хяналтын багт орж, 2 удаа төслийн ажилтай газар дээр нь танилцан холбогдох зөвлөмж, санал өгсөн.

Төслийн урьдчилсан хяналтад гэрээт ажлуудын хувьд Дэлхийн банкнаас тухайн гэрээт ажлын ХАА болон бэлтгэсэн сонгон шалгаруулалтын бичиг баримтын аливаа дутагдлыг урьдчилан харж, зохих зөвлөмжийг өгдөг. Сонгон шалгаруулалтын саналын үнэлгээг Үнэлгээний хорооны гишүүд хийж, олонхийн саналаар эцсийн шийдвэрийг гаргадаг бөгөөд Дэлхийн банкнаас зөвшөөрөл авах явцад Үнэлгээний хорооны гаргасан шийдвэрт эргэлзэх асуудал гарч байгаа нь сонгон шалгаруулалтын явцыг удаашруулах нэг шалтгаан болж байна.

2.5.7 Статистик үзүүлэлт

2012 онд төслийн хүрээнд хэрэгжсэн сонгон шалгаруулалт (СШ), гэрээний статистик үзүүлэлтийг дараахи хүснэгт, зурагт нэгтгэн харуулав:

Хүснэгт 8. ХАА-нд зарцуулсан хугацаа

| № | Гэрээний төрөл | ДБ-ны Төслийн ХАА-ны гарын авлагад тусгасан | Бодит хэрэгжилт (дундаж үзүүлэлт) |
|---|-----------------------------------------|---------------------------------------------|-----------------------------------|
| 1 | Ажил | | |
| а | СШББ-д ДБ-ны зөвшөөрөл авах | 38 | 19 |
| б | Зарлал | 33 | 32 |
| в | Үнэлгээ | 10 | 29 |
| г | Үнэлгээний тайланд ДБ-ны зөвшөөрөл авах | 12 | 7 |
| д | Гэрээ байгуулах | 5 | 12 |
| | Нийт | 97 | 99 |

Хүснэгтээс харахад дотоодын сонгон шалгаруулалт нь хугацааны хувьд сонгон шалгаруулалтын бичиг баримтын хяналт, зөвшөөрөл авахаас бусад үе шатууд зохих хугацаандаа хэрэгжсэн байна.

2.6 САНХҮҮЖИЛТ

2.6.1 Төслийн хөрөнгө зарцуулалтын байдал

2012 онд Японы Нийгийн хөгжлийн сангийн буцалтгүй тусламжаас нийтдээ 1,248.8 мянган ам долларыг зарцуулж, оны эцсийн байдлаар төслийн нийт хөрөнгийн зарцуулалт 48% хувьтай байна. Эдгээрээс 963.4 мянган ам долларыг иргэдийн оролцоотой болон мэргэжлийн байгууллагуудын хийж гүйцэтгэсэн барааболон ажилд, 9.2 мянган ам.долларыг зөвлөх үйлчилгээнд, 11.0 мянган ам.долларыг сургалтад, 203.5 мянган ам. долларыг төслийн үйл

БҮЛЭГ II. ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ДЭМЖИХ ХОЁР ДАХЬ ТӨСӨЛ

ажиллагааны зардалд, 61.1 мянган ам.долларыг иргэдийн хөдөлмөрийн хөлсөнд тус тус олгосон болно.


Хүснэгт 9. Буцалтгүй тусламжийн хөрөнгөөр 6 дүүрэгт 2012 онд нийтдээ 1698.0 сая төгрөгийн бүтээн байгуулалтын ажил хийгдсэнийг доорх хүснэгтээр харуулав.



2.6.2 Үр шим хүртэгчид

Тайлант жилийн хугацаанд төслийн хүрээнд нийт 512 ажилгүй, орлого багатай иргэнийг түр ажлын байраар хангаж, 9216 хүн өдрийн ажлыг гүйцэтгэв. 2012 оны төслийн хэрэгжилтийг үнэлэн дүгнэх зорилгоор шууд үр шим хүртэгч буюу тус онд түр ажлын байраар хангагдсан 344 иргэнээс санал асуулгын судалгааг авч доорхи дүгнэлтийг хийв.

Зураг 17. Орлогын зарцуулалт




Төслийн хүрээнд нэмэгдүүлсэн өрхийн орлогоо хэрхэн зарцуулсан талаархи асуултанд 71,1% нь гэр ахуйн хэрэгцээнд зарцуулсан, 23,3% нь гэр, хашаагаа тохижуулсан, зассан, 5,6% нь жижиг үйлдвэрлэлдээ нэмж эргэлдүүлж байна гэсэн хариултыг өгчээ. Гэр хорооллын иргэдийн өнөөгийн амьжиргаа, өрхийн хэрэгцээнээс үндэслэн аливаа орлогоо үрж зарцуулах хандлага түлхүү ажиглагдаж байгаа хэдий ч гэр бүлдээ хөрөнгө оруулалт хийх, бичил бизнес

БҮЛЭГ II. ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ДЭМЖИХ ХОЁР ДАХЬ ТӨСӨЛ

хийх санаачлага, оролдлого хийх болсон иргэдийн сэтгэлгээнд гарч буй эерэг өөрчлөлтийн нэг юм.

Зураг 18. Ажил эрхлэлтийн байдал



Судалгаанд оролцогчдын 96% нь ажилгүй, 4% нь ажилтай гэсэн хариултыг сонгосон бөгөөд ялгангуяа бага насны хүүхэдтэй, өрх толгойлсон эцэг эхчүүд гэрийнхээ ойролцоо ажил хийх, хийсэн даруйдаа цалингаа авдаг энэ хэлбэр нь тэдэнд их таалагдаж байгааг онцлон тэмдэглэв.

Төслийн хэрэгжилт, түр ажлын байраар хангахтай холбоотой дараахи санал хүсэлтийг иргэд хуваалцсан. Хариултыг өндөр давтамжаас буурах эрэмбээр жагсаав.

- Бүтээн байгуулалтын ажлын тоог нэмэгдүүлэх, ажлын боломжийг нэмэгдүүлэх
- Иргэдийн бүлгийн тухай хуультай болох
- Бүлгийн гишүүдийн үйлдвэрлэдэг бүтээгдэхүүнүүдийг борлуулах дэлгүүртэй болох
- Бараа материалыг нийлүүлдэг нэгдсэн цэгтэй болох
- Барилгын материалын чанар, үнийн судалгааг хийж иргэдэд тогтмол мэдээлэх
- Барилгын ажлыг 4-5 сард эхлүүлж 9 сард дуусгах буюу хүйтний улиралд бүх ажлыг дуусгасан байх
- Бүтээн байгуулалтыг хийснээс хойш 3-н жил арчлах, хамгаалах төсвийг гэрээнд эсвэл дүүргийн төсөвт оруулж өгөх
- Ажилгүй хүмүүсийн татварт 10% шимтгэл авч байгааг болих
- Төслийн шугамаар зээл олгох
- Бүлгүүдийг тоног төхөөрөмжтэй болгох

2.7 ДҮГНЭЛТ

2.7.1 Олон нийтийн зохион байгуулалт, хамтын ажиллагааны чиглэлээр:

- a) 2012 оны төлөвлөгөө 98%-иар биелсэн. Салангид ажилладаг иргэдийн бүлгүүд дүүрэг, дүүргээрээ нэгдэн "Холбоо"-ны хэлбэрээр зохион байгуулагдсан нь иргэдийн алсын хараа, харилцаа холбоог өргөжин тэлэхэд эерэгээр нөлөөлж байна. Холбооны зохион байгуулалт нь бүлгүүдийн дунд өрсөлдөөнийг үүсгэж бүлгүүд бие биедээ шаардлага тавих, дэмжин туслах эерэг өөрчлөлтүүд гарч байна.
- b) Ажил гүйцэтгэх иргэдийн бүлгүүдийн хүрээг тэлэх, үр шим хүртэгчдийн
- c) тоог нэмэгдүүлэх чиглэлээр анхаарч ажиллах.

БҮЛЭГ II. ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ДЭМЖИХ ХОЁР ДАХЬ ТӨСӨЛ

- d) Бүлгүүдийн зүгээс хөршүүддээ гэр хорооллын бусад иргэдэд үзүүлэх нөлөөллийг нэмэгдүүлэх буюу иргэд, иргэддээ чиглэсэн нийгмийн нөлөөлөл, сурталчилгааны ажлын хүрээг өргөжүүлэх шаардлагатай.
- e) Олон нийтийг зохион байгуулах арга барил, үзэл баримтлал, үнэт зүйлтэй болж тэдгээрийг мэргэжлийн багш, оюутнууд, төсөл, хөтөлбөрүүд, иргэд, бүлгүүдтэй хуваалцаж байгаа нь иргэдийн оролцоог дэмжих анхдагч төслийн хувьд чухал үүргийн нэг юм. Цаашид энэ чиглэлээр тодорхой зорилтот бүлгүүд болох мэргэжлийн олон нийт, төрийн байгууллагынхан, хэвлэл мэдээлэл, судлаачид, иргэний нийгмийн байгууллагууд зэрэгт зориулсан тодорхой хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан нөлөөллийн ажлыг хийх шаардлагатай байна.

2.7.2 Худалдан авах ажиллагааны чиглэлээр:

Төсөл хэрэгжих явцад худалдан авах ажиллагаанд оролцсон ТУН-ийн ажилтнууд, гүйцэтгэгч, зөвлөгч байгууллагууд ХАА-ны талаар тодорхой мэдлэгтэй болж, туршлагатай боллоо. Ялангуяа иргэдийн бүлгүүд өөрсдөө санаачилан амьдрах орчноо тав тухтай, тохилог, таатай болгох бичил төслийнхөө баримт бичгийг бэлтгэх, гэрээ байгуулахад шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах мэдлэг туршлагатай болж, байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргээ сайтар ухамсарлан амласан ажлаа амжилттай дуусгах хүсэл эрмэлзлэлийн сацуу өндөр хариуцлага хүлээж ажилласан юм. Үүний үр дүнд иргэдийн бүлэгтэй байгуулсан нэг ч гэрээ гүйцэтгэгчийн буруугаас цуцлагдаж, ажил цалгардаагүй юм. ЯНХС-гийн зохицуулагч нар Үнэлгээний хороонд орж ажиллан сонгон шалгаруулалтын явц, үнэлгээний талаар зохих мэдлэг туршлагатай боллоо.

БҮЛЭГ 3. ГЭР ХОРООЛЛЫН АЙЛ ӨРХИЙГ ЦЭВЭР, БОХИР УСНЫ СИСТЕМД ХОЛБОХ ЗАГВАР ТӨСӨЛ


3.1 ДАМБАДАРЖААГИЙН ЗАГВАР ТӨСЛИЙН ТАЛААР АВСАН АРГА ХЭМЖЭЭ

Улаанбаатар хотын Нийтийн аж ахуйг сайжруулах хоёр дахь төслөөр барьж байгуулсан Дамбадаржаагийн гэр хорооллын 96 айл, 8 байгууллагыг цэвэр, бохир усны шугам сүлжээнд холбож, бохирыг цуглуулан цэвэрлэж байгальд нь шингээх бага хүчин чадлын цэвэрлэх байгууламжийн ашиглалтад тодорхой хүндрэл гарсан учраас 2012 онд зарим арга хэмжээг авч хэрэгжүүлэв.

- Системийг 2011-2012 оны өвлийн улиралд хэвийн ажиллуулах
- Айл өрхийн бохирын шугаманд үүссэн хөлдөлтийг арилгах, Цэвэрлэх байгууламжийн шингээлтийг сайжруулах, технологийг боловсронгуй болгох арга хэмжээ авах
- Системийн ашиглалтыг сайжруулах талаар ТУН-ийн зүгээс хүчин чармайлт гаргах

Дамбадаржаагийн систем дээр техникийн комисс 2011 оны 11-р сарын сүүлээр ажиллаж, өгсөн үүрэг даалгаврын биелүүлж байх явцад өвлийн тэсгим хүйтэн эхэлж, айл өрхийн шугамууд хөлдөж, мөн цэвэрлэх байгууламжийн шингээх чадвар муудсанаас цэвэрлэх байгууламж дээр гол хүндрэл үүссэн. Иймд хүндрэлийг арилгах талаар УСУГ-ын удирдлагуудтай зөвлөлдөж, өвлийг даван туулахын тулд хүлээн авах камераас бохир усыг машинаар тээвэрлэх шийд гаргасан. Ингээд ТУН-ээс өвлийн турш усыг зөөх 8.2 сая төгрөгийн хөрөнгийг шийдвэрлэж, УСУГ-т шилжүүлсэн.

Зураг 19. Судалгааны үр дүн



Айл өрхийн шугаманд үүссэн хөлдөлтийг арилгах ажлыг гүйцэтгэгчид хийж гүйцэтгэсэн бөгөөд УСУГ-ын ажилтнууд тодорхой хэмжээгээр оролцож байсан. Айл өрхүүдийн дунд хийсэн судалгааны дүнгээс үзвэл барилгын ажлын гүйцэтгэгчид түлхүү оролцсоныг харж болохоор байна.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Э.Бат-Үүлийг 2012 оны 8-р

сардБаянхошууны ус хангамжийн системтэй танилцах үеэр Дамбадаржаад үүсээд байгаа хүндрэлийг арилгахад хотоос санхүүгийн дэмжлэг үзүүлэхийг хүссэн. Засаг дарга энэ асуудлыг судлан үзэж, 117 сая төгрөгийн хөрөнгийн асуудлыг шийдвэрлэж өгсөн. Уг хөрөнгөөр цэвэрлэгдэж гарсан усыг хадгалах далан барих, бохирын шугамуудад халаалтын утас сүвлэх ажлуудыг Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан хийж гүйцэтгэж байна.

БҮЛЭГ III. ГЭР ХОРООЛЛЫН АЙЛ ӨРХИЙГ ЦЭВЭР, БОХИР УСНЫ СИСТЕМД ХОЛБОХ ЗАГВАР ТӨСӨЛ


Дамбадаржаагийн асуудлаар ЗАА, УСУГ, гүйцэтгэгчид, ТУН-ийн ажилтнуудын оролцсон уулзалтуудыг нийтдээ 7 удаа хариуцан зохион байгуулсны 2-ыг УСУГ дээр, 2-ыг ТУН дээр 3-ыг ЗАА дээр тус тус хийснээс гадна зөвхөн Дамбадаржаагийн асуудлаар Дэлхийн банкны төслийн удирдагч Тоёоко хоёр удаа хотын даргатай уулзаж ярилцсан.

3.2 СУДАЛГААНУУД

а) Төслийг удирдах нэгжийн судалгаа

Улаанбаатар хотын Ерөнхий менежерээс өгсөн үүргийн дагуу ТУН-ийн ажилтнууд Дамбадаржаагийн шугаманд холбогдсон айл өрхийн дунд судалгаа явуулсан. Судалгаанаас харахад шугаманд холбогдсон айл өрхүүдэд дараахи эерэг өөрчлөлт гарсан байна.

Зураг 20. Айл өрхүүдэд гарсан өөрчлөлтүүд



Шугаманд холбогдсон айл өрхүүдийн 55% нь гэртээ усанд орох боломжтой болсноор тэдний эрүүл ахуйн нөхцөл сайжрах, улмаар халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдсэн байна.

Айл өрхүүд шугаманд холбогдсон нь гэр хорооллын иргэдийн эрүүл мэнд, тав тух, эдийн засгийн байдалд нь хэрхэн нөлөөлснийг судласан судалгааны дүнгээс харахад тэдний үл хөдлөх хөрөнгийн үнэ өссөнд иргэд сэтгэл хангалуун байгааг хамгийн олон хүн эерэг өөрчлөлт гэж үзсэнийг График 2-оос харж болно.

Энэхүү судалгааг үндэслэн бид дараахи дүгнэлтийг хийж байна.

- Айл өрхүүдийг цэвэр, бохир усны шугамд холбох нь гэр хорооллын иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, ариун цэврийн нөхцөл орчныг сайжруулахад чухал ач холбогдолтой болсон.
- Усны хэрэглээг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлсэн хөрөнгө оруулалтын, ухуулга сурталчилгааны арга хэмжээг авах шаардлагатай.
- Шугамд холбогдсон айл өрхүүдийн өвлийн цахилгааны зардалд хөнгөлөлт үзүүлэх
- Бие даасан цэвэрлэх байгууламжийн ашиглалтыг авч явах талаар УСУГ-ын ажилтнуудын хандлага, мэдлэг, туршлагыг эрс сайжруулах шаардлагатай гэж үзэж байна.

б) Дэлхийн банкны судалгаа

Дамбадаржаагийн системийг судлах, үнэлэлт өгөх зорилгоор Дэлхийн банкнаас 2012 онд хяналтын 3 баг ирж ажиллан, олон улсын тэр

БҮЛЭГ III. ГЭР ХОРООЛЛЫН АЙЛ ӨРХИЙГ ЦЭВЭР, БОХИР УСНЫ СИСТЕМД ХОЛБОХ ЗАГВАР ТӨСӨЛ

тусмаа хүйтэн орны туршлагатай гадаадын зөвлөх мэргэжилтнүүд өөр өөрсдийн үнэлгээ дүгнэлтийг гаргасны үндсэн дээр туршлага солилцох уулзалт семинарыг зохион байгуулав. Хяналтын багуудын зүгээс бодит байдлыг газар дээр нь судлаж үзээд дараахи дүгнэлтийг хийжээ.

- Айл өрхүүдээс цэвэрлэх байгууламжид ирж байгаа бохир усны хэмжээ тун бага байгаагаас бохирын шугам бөглөрөх, хөлдөх асуудал гарч байна.
- Зураг төслийг хийхдээ Дамбадаржаагийн оршин суугчдын бодит хэрэглээг хэт өндөр тооцоолсон.
- Цэвэрлэх байгууламжийн байрлал нь голын сайрт учир зуны улиралд хөрсний усны төвшин өндөр байгаагаас Цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна. Био цөөрмийг барих нь бохир усыг гадагшлуулах талбайг нэмэгдүүлж байгаа хэдий ч зуны улиралд гадаргын усны төвшин нэмэгдэх, өвлийн улиралд бол хөлдөж, үйл ажиллагаа нь доголдож болзошгүй.
- Айл өрхөөс гарч байгаа бохир усыг цэвэрлэх байгууламжид цэвэрлэх энэ хэлбэрээр нь үйл ажиллагааг нь сайжруулахад зардлын хувьд маш өртөг өндөртэй, алсдаа УСҮГ болон хотоос ихээхэн хэмжээний татаас шаардана.

Дамбадаржаагийн гэр хороололд хэрэгжүүлсэн айл өрхийг цэвэр бохир усны шугам сүлжээнд холбох загвар төсөл нь сэтгэл дундуурхан үр дүн үзүүлсэн хэдий ч нөгөө талаар маш чухал сургамжийг өгч байгаагаараа ач холбогдолтой.

3.3 ДҮГНЭЛТ

Эдгээр нөхцөл байдлыг харгалзан үзээд дараахи асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байгааг санал болгосон юм.

- Цэвэрлэх байгууламжийг нь бохир ус цэвэрлэх зориулалтаар ашиглалгүйгээр бохир усыг цэвэрлэхэд зориулагдсан тоног төхөөрөмжүүдийг нь өөр бусад цэвэрлэх байгууламжид ашиглах.
- Септик танк суурьлуулах замаар гэр хорооллын бохирын асуудлыг нэн тэргүүнд шийдвэрлэх.
- Оршин суугчдын цэвэр, бохир усны хэрэглээний хэрэгцээ, шаардлагын талаар нарийвчилсан судалгаа, шинжилгээг хийх.
- Дамбадаржаагийн бохир усны асуудлыг шийдэх хамгийн сайн шийдлийг олох хүртэл гэр хорооллын ус хангамжийн шугам сүлжээнд оруулах шаардлагатай хөрөнгө оруулалтаа маш сайн эрэмблэж байх.
- Хотын захиргаа хэд хэдэн анализ дүн шинжилгээг, хэрэв өмнө нь хийгээгүй бол, хөгжлийн түншүүдийн дэмжлэгтэйгээр хийх. Нэн тэргүүнд хийх хамгийнчухал алхам нь гэр хорооллын ус болон бохир усны асуудлыг шийдэх зургийн стандартыг эргэн хянаж үзэх.
- Гэр хорооллын бодит байдал, хүмүүсийн ус хэрэглэх дадал зуршил, хандлага, цэвэр бохир усны үйлчилгээний эрэлт хэрэгцээний талаар илүү нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай байгааг Нийслэлийн Засаг дарга

БҮЛЭГ III. ГЭР ХОРООЛЛЫН АЙЛ ӨРХИЙГ ЦЭВЭР, БОХИР УСНЫ СИСТЕМД ХОЛБОХ ЗАГВАР ТӨСӨЛ

бөгөөд Улаанбаатар хотын захирагч Э.Бат-Үүлд 2012 оны 11-р сарын 15-ны өдөр илгээсэн албан захидалдаа өгүүлсэн.

3.4 ХӨРӨНГӨ ЗАРЦУУЛАЛТ

Улаанбаатар хотын Нийтийн аж ахуйг сайжруулах төсөл 2012 оны 2-р сарын 29-ний өдрөөр дуусгавар болж, 5-р сарын 30 гэхэд төслийн эцсийн тооцоог гаргаж, холбогдох байгууллагуудад явуулан, данснуудыг хаасан болно. 2012 онд УБНААСТ-ийн данснаас 363 мянган төгрөг зарцуулжээ.

Данс хаагдахад зээлийн нийт хөрөнгө 18 сая доллараас 18,6 сая долларын нийт зарцуулалт хийж, тусгай дансанд бодогдсон 15,2 мянган ам.долларыг Сангийн яамны данс руу шилжүүлэн, хаасан болно.

БҮЛЭГ 4. УЛААНБААТАР ЦЭВЭР АГААР ТӨСӨЛ

4.1 УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР АВСАН АРГА ХЭМЖЭЭ

4.1.1 Төслийн бэлтгэл ажил

Дэлхийн банкны 15.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлээр санхүүжигдэх “Улаанбаатар-цэвэр агаар” төслийн концепцийг хэлэлцэх, төслийн хүрээнд хийх ажлыг эцэслэн шийдвэрлэх, засгийн газар, нийслэлийн бодлого шийдвэртэй уялдуулах зорилгоор оролцогч бүх талуудтай хамтарч ажиллаж ирлээ.

Улаанбаатар-Цэвэр агаар төслийн бэлтгэл ажлын хүрээнд дараахи гэрээнүүдийн ажлын удирдамжийг боловсруулж, оролцогч талуудаас санал зөвлөмжийг авах ажлыг хэд хэдэн удаагийн давталттайгаар хийж гүйцэтгэв. Үүнд:

- Ахуйн хэрэгцээний усан халаалтын зуухны тооллого, зах зээлийн судалгаа хийх зөвлөх багийн ажлын удирдамжийг 2 удаа хянан засварлав.
- Лаборатори, зуух хөгжлийн төвд зөвлөх үйлчилгээ үзүүлэх зөвлөх багийн ажлын удирдамжийг эцэслэв.
- Төвлөрсөн дулаан хангамжийн өнөөгийн байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, улмаар Улаанбаатар хотын дулаан хангамжийн хэтийн төлөв, техник эдийн засгийн үндэслэл боловсруулах судалгааны ажлын удирдамжийг ЭХЯ-ны бодлого зохицуулалтын газар, Дулааны сүлжээ ХХК, ЗАА-ны ИБХ зэрэг газруудад хүргүүлж саналыг тусгасны үндсэн дээр эцэслэв.
- Цахилгаан станцуудын яндангаас ялгарч байгаа хорт утааг болон үнсэн сангийн дэгдэмхийн тоос тоосонцрыг турших судлах, гарсан үр дүн дээр суурилан цаашид авах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах, зөвлөмж гаргах зөвлөх үйлчилгээний ажлын удирдамжийг эрчим хүчний яамны бодлогын хэлтсийн ажилтнуудын хамт дахин боловсруулж, Дэлхийн банкны зөвшөөрлийг авав.
- Боломжийн өртөгтэй орон сууцны стратеги боловсруулах зөвлөхүйлчилгээний ажлын удирдамжийг Барилга Хот Байгуулалтын Яаманд 2 удаа хүргүүлэн санал зөвлөмж авч эцэслэв
- Улаанбаатар хотын ногоон байгууламжийн өнөөгийн байдалд үнэлэлт дүгнэлт өгч ТЭЗҮ боловсруулах судалгааны ажлын удирдамжийг хянан эцэслэв.



Зураг 21. ТУХ-ны хурлын үеэр

Цэвэр агаар төслийн ТУХ-ны хурлыг хуралдуулж, төслийн гэрээ байгуулахад шаардагдах баримт бичгүүдийг хэлэлцэн батлуулав. Үүнд:

- Төслийн хүрээнд хийгдэх ажлууд (бүрэлдэхүүн хэсгээр)
- Эхний 18 сарын төлөвлөгөө
- Эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүжилт, хэмжээ

- Зөвлөх үйлчилгээний ажлын удирдамжууд
- Үйл ажиллагааны гарын авлага зэрэг болно.

Төслийн гэрээ хүчин төгөлдөр болох 2нөхцлийг бүрдүүлэхэд анхаарлаа хандуулан ажиллав. Эхний нөхцөл нь Улаанбаатар хотын захиргаанаас төслийн гэрээнд хуулийн дүгнэлт гаргуулах нөгөө нь “Зуухны утаа, үр ашгийн туршилтын лаборатори”-ийн эзэмшлийн асуудлыг шийдвэрлэх явдал байв.

2012 оны 4-р сарын 27-нд НЗДТГ-аас Дэлхийн Банкнд албан тоот илгээж, төслийн болон зээлийн гэрээ нь хуулийн хүрээнд боловсруулагдсан болохыг хүлээн зөвшөөрснөөр эхний нөхцөл хангагдсан.

АХБ-ны санхүүжилтээр байгуулсан “зуухны утаа, үр ашгийг турших лаборатори”-ийн тасралтгүй, тогтвортой ажиллагааг хангах нь төслийн зорилтуудын нэг байв. Улаанбаатар-Цэвэр агаар төслийн санхүүжилтэд уг лабораторийн үйл ажиллагааны зардал, зуухнуудын туршилт, олон улсын зөвлөхүүдийн мэргэжлийн зөвлөгөө, дутагдаж байгаа тоног төхөөрөмжийн ханган нийлүүлэлт зэргийг багтаасан учраас лабораторийн эзэмшлийн асуудлыг тодорхой болгох нь нэн чухал байв.

2012 оны 8-р сарын 17-нд Эрдэс баялаг эрчим хүчний яам (хуучин нэрээр) болон Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам (хуучин нэрээр)-ны хооронд байгуулсан харилцан ойлголцлын санамж бичигт уг лабораторийг өмчийн хувьд БСШУЯ-нд буюу ШУТИС-д шилжүүлээр шийдвэрлэсэн боловч зарим заалтууд нь өөр хоорондоо зөрчилдсөн байсныг нарийвчлан тодруулах шаардлага гарсан. Тухайлбал. Лаборатори өмчийн хувьд ШУТИС-т очоод байхад ЭБЭХЯ түүний үйл ажиллагааны болон бизнесийн асуудалд хяналт тавина гэж бичигдсэн болон лабораторийн үйл ажиллагааг ШУТИС-ын харьяа Дулаан, үйлдвэрлэл экологийн хүрээлэн (лабораторийн үйл ажиллагааг өнөөг хүртэл хариуцан, зуухны төрөл бүрийн туршилтыг хийж ирсэн туршлагатай)-д хариуцуулахын оронд ШУТИС-ийн уул уурхайн хүрээлэнд хариуцуулна гэж заасан байв.

Энэ асуудлыг шийдвэрлэхээр Төслийг удирдах нэгж нь Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, Нийслэлийн засаг даргын экологийн асуудал хариуцсан орлогч, БШУЯ, ЭХЯ-ны болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран ажилласны үр дүнд ЭХЯ болон БШУЯ-аас албан бичиг авч лабораторийн эзэмшлийн асуудлыг эцэслэн шийдвэрлэлээ.

4.2 ТӨСӨЛ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛЖ БАТЛАГДАВ.

Төслийн гэрээ, зээлийн гэрээг засгийн газрын нэгдсэн хуралдаан, Эдийн засгийн болон аюулгүй байдлын байнгын хороодоор хэлэлцүүлэн 2012 оны 5-р сарын 19-нд Улсын их хурлаар батлуулав.

Дээр дурдсан 2 үндсэн нөхцөл хангагдсан учраас 2012 оны 12 сарын 18-нд төслийн хөрөнгө зарцуулах эрх нээгдэж төсөл хүчин төгөлдөр болов.

4.3 ТӨСЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА

Цэвэр агаар төслийн хүрээнд Нийслэлийн Засаг даргын захирамжаар нийтдээ 5 гэрээний үнэлгээний хороог байгуулаад байгаа ба гэрээ тус бүрийн явцыг дараах байдлаар харуулав.

Гэр хорооллын тоосонцрын хэмжээг бууруулах ажлын хүрээнд

а) Лаборатори болон Зуух боловсронгуй болгох төвд зөвлөхийн үйлчилгээ:

Энэ гэрээний сонгон шалгаруулалт 2011 оны 12-р сарын 1-нд зарлагдаж 5 компани сонирголоо илэрхийлсэн. Эдгээрээс 2 компани техникийн болон санхүүгийн саналаа ирүүлснээс үнэлгээний хорооны шийдвэрээр Мон-Энержи ХХК-ийг шалгаруулав.

б) Ахуйн хэрэгцээний усан халаалттай зуухны зах зээлийн судалгааг хийх зөвлөхийн үйлчилгээ:

Сонгон шалгаруулалт 2012 оны 1-р сарын 4-нд зарлагдаж, 5 оролцогч сонирголоо илэрхийлсэн. Техникийн саналаар хамгийн өндөр үнэлгээ авсан MMGG ХХК болон ШУТИС-ийн ВЕЕС-төвийн түншлэлийн санхүүгийн санал нь хяналтын төсвөөс хэт өндөр байсан учраас үнэлгээний хорооны шийдвэрээр дахин зарлахаар болсон.

Улаанбаатар хотын төвийн хэсгийн тоосонцрын хэмжээг бууруулах ажлын хүрээнд

а) Боломжийн өртөгтэй орон сууцны стратеги боловсруулах зөвлөхийн үйлчилгээ:

Сонгон шалгаруулалтыг 2012 оны 5-р сарын 25-нд зарлаж, 5 оролцогч сонирголоо илэрхийлсэн хүсэлт ирүүлсэн. Үнэлгээний явцад техникийн болон хүний нөөцийн шаардлага хангахуйц оролцогч байхгүй байснаас тендерийг дахин зарласан.

Дахин зарласны дараа 12 байгууллага тендерт оролцох хүсэлтээ илэрхийлээд байна. Үнэлгээний хорооны дарга солигдсонтой холбоотойгоор засаг даргын дахин захирамжийг дахин гаргуулах шаардлага гарсан. Энэхүү асуудлыг шийдвэрлүүлэхээр хотын захиргаанд хүсэлт тавиад байна.

б) Нийслэл хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ТЭЗҮ боловсруулах судалгааны зөвлөхийн үйлчилгээ:

2012 оны 4-р сарын 2-нд сонгон шалгаруулалтыг зарласан. 9 оролцогч сонирголоо илэрхийлсэн. Эдгээрээс 6 байгууллагыг богино жагсаалтанд оруулсан. Богино жагсаалтанд орсон оролцогчдын зөвхөн 2 нь техникийн болон санхүүгийн саналаа ирүүлсэн ба үнэлгээний хорооны гишүүд техникийн саналыг үнэлээд байна. Үнэлгээний хорооны дарга солигдсон дээрхтэй ижил шалтгаанаар үнэлгээний явц түр саатаад байна.

с) Олон нийтэд чиглэгдсэн мэдээлэл, сурталчилгааны компанит ажил явуулах зөвлөх үйлчилгээ:

Сонгон шалгаруулалт 2012 оны 5-р сарын 22-нд зарлагдсан ба 6 оролцогч сонирголоо илэрхийлсэн хүсэлт ирүүлсэн. Ажлын туршлага, хүний нөөцийн мэдээллээр шаардлага хангасан оролцогч байгаагүй тул үнэлгээний хорооны шийдвэрээр сонгон шалгаруулалтыг дахин явуулахаар шийдвэрлэсэн.

4.4 ҮНДЭСНИЙ БОЛОН ХОТЫН БОДЛОГОТОЙ УЯЛДУУЛАХ НЬ

УБЦАТ-ийн үйл ажиллагааг эхлүүлэх, тулгамдаж байгаа асуудлуудыг шийдвэрлэх, засгийн газрын болон орон нутгийн эрх бүхий байгууллагын дэмжлэгийг авах зорилгоор Дэлхийн Банкны баг Улаанбаатар хотноо 3 удаагийн айлчлал хийв. Үүнд:

а) Улаанбаатар-цэвэр агаар төслийн зорилго, зорилтыг Засгийн газрын болон нийслэлийн бодлого шийдвэртэй уялдуулах, агаарын бохирдлын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа бусад төсөл хөтөлбөрүүдтэй УБ-Цэвэр агаар төслийг уялдуулах, Мянганы сорилын сангийн төслийн хэрэгжилтийн явцад буй болсон мэдээллийн сан, зуух борлуулах бэлэн механизмыг Цэвэр агаар төсөлд олгуулах зэрэг асуудлаар удирдах албан тушаалтнуудтай уулзалт хийв. Тухайлбал: Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны дарга П.Цагаан, Байгаль орчин ногоон хөгжлийн яамны сайд С. Оюун, Эрчим хүчний яамны дэд сайд Д. Доржпүрэв, Цэвэр агаар сангийн захирал Н. Хүрэлсүх, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Д.Баттулга болон бусад албаны хүмүүстэй уулзав.

б) Дэлхийн банкны хяналтын баг Эрчим хүчний яамны Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын дарга П. Товуудорж, мэргэжилтэн Д. Пүрэвбаяр, Бямбаахүү, Ё. Энхтуяа, Дулааны сүлжээ компаний захирал Р. Хайдав, ерөнхий инженер Мөнхжаргал мэргэжилтэн А. Эрбар нартай уулзалт зохион байгуулж төслийн талаар ялангуяа ТЭЦ-үүдээс гарч байгаа тоос тоосонцор, төвлөрсөн дулаан хангамжийн ТЭЗҮ боловсруулах ажлын талаар мэдээлэл хийж, хамтран ажиллах талаар уулзаж ярилцав.

с) Дэлхийн банкны хяналтын хэсгийнхэн эрчим хүчний яамны бодлогын хэрэгжилтийг хангах газрын түлшний хэлтсийн орлогч дарга Болдхүүд лабораторийн эзэмшлийн асуудал, түрээсийн асуудал, шинэ байрлал руу лабораторийг нүүлгэн шилжүүлэхэд учирч болох техникийн ур чадвартай холбогдолтой хүндрэлтэй асуудал зэргийг шийдвэрлэх талаар нарийвчилсан саналыг танилцуулж байв.

4.5 УЛААНБААТАР ЦЭВЭР АГААР ТӨСЛИЙН ХӨРӨНГӨ ЗАРЦУУЛАЛТ

Улаанбаатар цэвэр агаар төслийн зээлийн хөрөнгийг зарцуулах тусгай данс нээх ажлыг 2012 оны 11-р сараас эхлэн хөөцөлдсөн боловч тодорхой үр дүн гараагүй байна. Сангийн яамны зээл, тусламжийг зохицуулах хэлтсийн дарга Доржханд төслийн тусгай дансыг заавал Улаанбаатар банкинд нээх шаардлага тавьж байгаа нь ихээхэн цаг хугацаа алдахад хүргээд байна. Учир нь Улаанбаатар банк шаардлага хангах банк мөн эсэхийг Дэлхийн банкны зүгээс үнэлгээ хийх асуудал ихээхэн цаг хугацаа шаардаж байна.

Энэ төслийн хөрөнгө зарцуулалтын эрх 2012 оны 12-р сарын 18-нд нээгдсэн бөгөөд 2012 онд хөрөнгө зарцуулалт хийгдээгүй.

БҮЛЭГ 5. ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ

5.1 УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР АВСАН АРГА ХЭМЖЭЭ

5.1.1 Төслийн бэлтгэл ажил

Сүүлийн жилүүдэд Улаанбаатар хотод болсон гэнэтийн үерийн улмаас хэд хэдэн хүний амь эрсэдсэн нь үерийн гамшгийн эрсдэлийн менежментийг сайжруулах арга хэмжээг цаг алдалгүй авах шаардлагатайг харуулсан.



Зураг 22. БЗД-ийн 21-р хороонд болсон үер, 2012 оны 6-р сар

Үерийн гамшгаас урьдчилан сэргийлэх стратеги төлөвлөгөө, нэгдсэн мэдээллийн бааз, түүнд

тулгуурласан аврах ажиллагааны төлөвлөгөө, мэргэжлийн тоног төхөөрөмж дутагдалтай байсаар ирсэн. Иймд 2010 онд Нийслэлийн удирдлагууд, Нийслэлийн онцгой байдлын газраас Дэлхийн банкинд үерийн гамшгийн эрсдэлийг бууруулахад туслалцаа үзүүлэхийг хүссэн.

Үүний үр дүнд Дэлхийн банк “Гамшгийн эрсдэлийн менежментийг сайжруулах төсөл”, “УБ хотын НААСЗ дахь төслүүд”-ийг үерээс хамгаалах арга хэмжээг авахад зориулж хэрэгжүүлэхээр болсон.

“Гамшгийн эрсдэлийн менежментийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд хийх ажил, хэрэгцээ шаардлагыг тодорхойлохын тулд ТУН нь Онцгой байдлын Ерөнхий Газар, Нийслэлийн Онцгой Байдлын Газар, ЗАА-ны ИБХ, Ус цаг уур орчны хүрээлэнгийн мэргэжилтэнүүдтэй хамтран ажиллав. Нийт 6 удаа хамтарсан уулзалт зохион байгуулж, имэйлээр 21 орчим удаа харилцсан байна.

5.2 ТӨСӨЛ БАТЛАГДАЖ, ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛСОН НЬ

Гамшгийн эрсдэлийг бууруулах төсөл нь 2012 оны 6-р сарын 13 өдөр Монгол улсын Засгийн газар, Олон улсын хөгжлийн нийгэмлэг /Дэлхийн банк/, Японы засгийн газрын “Хүний нөөцийн хөгжлийн бодлогын сан”-гийн хоорондын гэрээгээр батлагдсан. Энэхүү буцалтгүй тусламжийн төсөл нь 2013-2014 онуудад хэрэгжих бөгөөд 1.3 сая ам долларын санхүүжилттэй.

Төслийн хэрэгжилтэд хяналт тавих байгууллага нь Нийслэлийн онцгой байдлын газар бөгөөд Нийслэлийн захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтэс, НЗДТГ-ын хэрэгжүүлэгч агентлаг Нийслэлийн ерөнхий төлөвлөгөөний газар, Ус цаг уурын хүрээлэнтэй хамтарч ажиллана.

5.3 ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР ХИЙСЭН АЖЛУУД

5.3.1 Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө

Төсөл нь Зөвлөхийн үйлчилгээ. Барааны ханган нийлүүлэлт гэсэн үндсэн 2 ангилалтай.

Зөвлөхийн үйлчилгээний хүрээнд:

- Улаанбаатар хотын үерийн эрсдэлийн бэлэн байдалд үнэлэлт дүгнэлт өгөх
- Улаанбаатар хотын үерт өртөмтгий газруудын зураглал хийх
- GIS мэдээллийн бааз байгуулах, холбогдох байгууллагуудыг мэдээллээр холбох
- Үерийн гамшгийн эрсдэлийг бууруулах урт хугацааны стратеги төлөвлөгөө боловсруулах
- Нийслэлийн үерийн асуудлыг хариуцсан байгууллагын ажилтнуудыг сургах, чадавхийг бэхжүүлэх

Бараа, материалаар ханган нийлүүлэх ажлын хүрээнд:

- НОБГ-т шаардлагатай тоног төхөөрөмжийг нийлүүлэх
- Нийслэлийн усны барилга байгууламж компанид тоног төхөөрөмж нийлүүлэх

5.3.2 Сонгон шалгаруулалт эхлэсэн гэрээнүүд, явц

“УБ хотын үерийн эрсдэлийн үнэлгээ хийх, үерийн эрсдэлийн менежментийн стратегиболовсруулах” зөвлөхийн үйлчилгээний гэрээг 2012 оны 11-р сарын 26 өдөр зарласан бөгөөд оролцохыг хүссэн байгууллагуудын саналыг хүлээн авч, үнэлгээний шатанд явж байна.

Үнэлгээний хороог Засаг даргын захирамжаар байгуулан Дэлхийн банкны журам болон Монголын бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийн хүрээнд сонгон шалгаруулалтыг явуулахаар бэлтгэж байна.

5.4 ТӨСЛИЙГ УЛСЫН БОЛОН ХОТЫН БОДЛОГОТОЙ УЯЛДУУЛАХ ТАЛААР АВСАН АРГА ХЭМЖЭЭ

5.4.1 Дэлхийн банкны багийн ажлын үр дүн

Дэлхийн банкны зүгээс төсөл батлагдсанаас хойш 3 удаа хотын харьяа газрууд болон НОБГ, ЗАА-ны ИБХ болон Жайкатай уулзалт зохион байгуулж, төслийн 2012-2014 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталж, эхний сонгон шалгаруулалтын ажлын удирдамжид зөвшөөрөл өгөөд байна.

5.4.2 Онцгой байдлын асуудал хариуцсан байгууллагуудын хамтын ажиллагаа, Сургалт

Монгол улсын засгийн газар гамшгаас хамгаалах тухай хуулийг (2003) боловсруулснаар гамшгийн үед авч хэрэгжүүлэх хариу үйлдэл, гамшгийн үр дагаврыг даван туулах хууль эрх зүйн орчинг бий болгож чадсан. Энэ хуулийг хэрэгжүүлэх зорилгоор 2004 оны Засгийн газрын тогтоолоор Иргэний хамгаалалтын газар, Гал тиймэртэй тэмцэх газар, Улсын нөөцийн газруудыг нэгтгэж Онцгой байдлын ерөнхий газрыг байгуулсан.

БҮЛЭГ V. ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ

Энэхүү байгууллагад Нийслэлийн онцгой байдлын газар болон аймгуудын Онцгой байдлын газрууд харьяалагддаг. Нийслэлийн онцгой байдлын газарт 9 дүүргийн онцгой байдлын газрууд, 13 гал унтраах анги, Шуурхай бүлэг 105 зэрэг анги нэгтгэлүүд хамаарагддаг.

Үерийн гамшиг тохиолдсон үед иргэдийн амь нас, эд хөрөнгийг хамгаалах үйл ажиллагаанд Нийслэл дүүргийн онцгой байдлын газрын аврах анги нэгтгэлүүд байхаас гадна НЗАА-ны ИБХ-ийн мэргэжилтнүүд, Нийслэлийн цагдаагийн газар, 103 –ийн эмч нар очиж үйлчилдэг.

Гамшгийн дараахи мэдээллийг НЗАА-ны Инженерийн байгууламжийн хэлтэс болон Барилга хот байгуулалт төлөвлөлтийн газрууд хотын мэдээллийн санд бүртгэж оруулдаг. Түүнчлэн Үс цаг уурын хүрээлэн хур тунадасны хэмжээг бүртгэж авдаг байна.

Хэдийгээр үер усны аюулаас сэргийлэх, хамгаалах үүрэг бүхий олон байгууллага байгаа ч нэгдсэн нэг бодлого, стратеги төлөвлөлтгүй, мэдээллийн бааз байхгүй, ажлын уялдаа холбоо муу, тоног төхөөрөмжийн хүртээмж суу зэргээс шалтгаалан аливаа гамшгаас хохирол амсах магадлал их байна.

Төслийн үйл ажиллагаа эхэлж байгаатай уялдуулан Дэлхийн банкны “Гамшгийн эрсдэлийн менежмент” сертификат олгох сургалтанд НОБГ-ын харьяа БГД-ийн онцгой байдлын газрын орлогч дарга Ц.Төрмандах, Төслийг удирдах нэгжийн мэдээллийн ажилтан Э.Батжаргал нар суралцаж, сертификат авав.

5.5 ДҮГНЭЛТ

Улаанбаатар хотын гамшгийн эрсдэлийг бууруулах төсөл хэрэгжснээр ҮБ хот нь үерийн гамшгийн эрсдлийн менежментийн стратеги төлөвлөгөөтэй болно. GIS систем дээр суурилагдсан үерийн мэдээллийн сантай болно.

Ингэснээр Нийслэлийн онцгой байдлын газар нь болон холбогдох байгууллагууд нь үерийн гамшиг болоод өнгөрсөн хойно биш харин урьдчилан сэргийлэх арга хэмжээг авдаг, тооцоолдог, харилцан мэдээллээ хуваалцдаг, ард иргэддээ цаг алдалгүй сэрэмжлүүлэг өгдөг болох нөхцөл бүрдэх юм.

5.6 ХӨРӨНГӨ ЗАРЦУУЛАЛТ

Энэхүү төслийн худалдан авах ажиллагаа эхэлсэн хэдий ч гэрээ байгуулагдаагүй учраас зөвхөн ТҮН-ийн удирдлагын зардалд зориулсан 20.5 мянган ам долларын хөрөнгийг зарцуулсан.

БҮЛЭГ 6. УЛААНБААТАР ХОТЫН НИЙТИЙН АЖ АХУЙГ САЙЖРУУЛАХ ГУРАВДАХЬ ТӨСӨЛ

6.1 ТӨСЛИЙН БЭЛТГЭЛ АЖИЛ

Улаанбаатар хотын нийтийн аж ахуйг сайжруулах гурав дахь төслийн зорилго нь дунд бүсийн гэр хорооллын оршин суугчдыг дэд бүтцийн үндсэн үйлчилгээгээр хангах, дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг ач холбогдлоор нь эрэмбэлэж тогтоох системийг УБ хотын захиргаанд нэвтрүүлэх, төлөвлөлт хийхэд хот, дүүргийн захиргааны чадавхийг сайжруулах замаар нутгийн удирдлагын механизмыг бэхжүүлж тухайн хэсгийн тогтвортой хөгжлийг дэмжихэд оршино.

Төсөл хэрэгжих дүүрэг хороодыг сонгох, төслийн хүрээнд хийгдэх ажлуудыг тодорхойлохдоо дунд бүсийн гэр хороололд амьдарч байгаа оршин суугчидтай, иргэдтэй, иргэдийн бүлгүүдтэй, хороо дүүрэг, хотын удирдлагуудтай уулзаж тэдгээрийн тэдгээрийн хүсэлт, эрэлт хэрэгцээг олж тогтоох, эрэмбэлэхэд анхаарлаа хандуулсан.

Хот, түүний харьяа байгууллагуудтай 25 удаагийн, дүүрэг хорооны засаг дарга нартай 20, иргэдийн бүлгүүд, оршин суугчидтай 12 удаагийн, хот тохижилтын газар, ТҮК зэрэг газруудтай 10 буюу нийтдээ 60 орчим удаагийн уулзалт, ярилцлагуудыг хийсэн.

6.2 ДЭЛХИЙН БАНКНЫ ХЯНАЛТЫН БАГ

Дэлхийн банкны хяналтын баг Улаанбаатар хотын НААСЗ төслийн шугамаар 5 удаа ирж ажилласан. Ус хангамж, байгаль орчин, хог хаягдал, хот төлөвлөлт, санхүү/эдийн засгийн мэргэжилтнүүдээс бүрдсэн энэхүү баг нь төслийн баримт бичгийг боловсруулах, засгийн газар, нийслэлийн бодлого шийдвэртэй төслийн зорилго, зорилтыг уялдуулах, иргэд, оршин суугчдын саналыг тусгах, оролцогч талуудын байр суурийг тодорхойлох, төслийн хэрэгжилтийн арга механизмыг боловсруулах, Дэлхийн банкны шаардлагад нийцсэн байгаль орчин, аюулгүй ажиллагаа, нүүлгэн суурьшуулалтын баримт бичгийг боловсруулахад голлон ажилласан. Албан томилолт тус бүрт санамж бичгүүдийг боловсруулж, томилолтын үр дүнг хотын ерөнхий менежерт тайлагнаж байв.

Дэлхийн банкны хяналтын хэсгээс гарсан гол үр дүн:

- ТЭЗҮ боловсруулах судалгааны бэлтгэл ажлыг хангах
- Сонгон шалгаруулалтын үр дүнд анализ хийх
- Төслийн хөрөнгө оруулалтыг эрэмбэлэх арга аргачлалыг боловсруулах
- Гэр хорооллын хөгжлийг дэмжих хөрөнгө оруулагчдын нэгдсэн бодлого төлөвлөлтийг боловсруулахад санал бэлтгэх
- Төслийн гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүдийг боловсруулах
- Судалгааны хамрах хүрээ, түүврийн оновчтой байдал, мэдээллийн үнэн бодит чанарыг баталгаажуулах зэрэг мэдээлэл цуглуулах, боловсруулах, дүн шинжилгээ хийх судалгааны техникийн зөвлөгөө
- Судалгаатай холбоотой төр захиргааны болон мэргэжлийн хүмүүс, хэлтэс, албадын саналыг авах, нэгтгэх, эргэн дүгнэх зэрэг санал өгч байсан байна.

БҮЛЭГ VI. УЛААНБААТАР ХОТЫН НИЙТИЙН АЖ АХҮЙГ САЙЖРУУЛАХ ГУРАВ ДАХЬ ТӨСӨЛ

- Байгаль орчин, үнэлгээнд баримтлах бодлогын баримт бичиг
- Нүүлгэн суурьшуулалтад баримтлах бодлогын баримт бичиг
- Аюулгүй ажиллагаа, хяналтын механизмыг боловсруулсан
- ТУН-ийн бүтэц, зохион байгуулалт, менежментийн төлбөрийг шийдвэрлэсэн

6.3 ТӨСЛИЙН ТЭЗҮ БОЛОВСРУУЛАХ СУДАЛГАА

УБ НААСЗ төслийн ТЭЗҮ боловсруулах судалгааг хийх зөвлөх багийн сонгон шалгаруулалтыг олон улсын нээлттэй тендер зарлан зохион байгуулсан.

Энэтхэгийн Ай Си Ти компани тендэрт шалгарч 8 сар ажиллахдаа дараахи гол үр дүнг гаргасан.

- Гэр хорооллын иргэд, оршин суугчидтай уулзан хэрэгцээг тодорхойлсон.
- Төсөлд хамрагдах гэр хорооллын шалгуур үзүүлэлтийг гарган сонголт хийсэн: 5 дүүрэг, 12 хороо
- Иргэд оршин суугчдын хэрэгцээнд үндэслэн УБНААСЗ-аар хийх ажлын чиглэлийг тодорхойлсон:
- Улаанбаатар хотын дэд бүтцийн асуудал хариуцсан хэлтэс, агентлагуудыг GIS мэдээллийн системд холбох ажлын удирдамжийг боловсруулсан
- Хог хаягдлын менежментийг боловсронгуй болгохиж бүрэн судалгаа хийсэн
- Хөрөнгө оруулалтын дээрхи чиглэлийн хүрээнд нэн тэргүүнд хийх дэд бүтцийн ажлуудыг тодорхойлж урьдчилсан зураг төслийг боловсруулсан
- ТЭЗҮБ судалгааг хийж хотын захиргаа, харьяа газрууд, хэлтэс тасгууд, дүүрэг хороодын дунд семинар зохион байгуулж тэдгээрийн саналыг тусгаж эцэслэсэн



Зураг 23. 2012 оны 1-р сарын 30 ТЭЗҮ боловсруулах судалгааны эцсийн хэлэлцүүлгийг хийсэн.

УБ НААСТЗ төслийн хүрээнд хийгдэх гэр хорооллын доторхи авто замуудын сонголтыг хийх, байршлыг эцэслэх, тавигдах стандартыг хэлэлцэх уулзалтыг Нийслэлийн авто замын газартай хэд хэдэн удаа зохион байгуулж, газар дээр нь хамтарч явж шийдвэрлэсэн.

6.4 ТӨСЛИЙН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН ХЭСГҮҮД

Төслийг 2013-2017 онд хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

Одоогийн байдлаар төслийн бүрэлдэхүүн хэсгийг дараахи байдлаар тодорхойлоод байгаа ба эдгээр бүрэлдэхүүн хэсэг бүрт төлөвлөсөн ажлуудыг дэмжих, бэлтгэлийг хангах зорилготой 2 буцалтгүй тусламжийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- 6 дүүргийн хөгжлийн төлөвлөлтийг хийх, дүүргийн ажилтнуудыг чадавхижуулах
- Үерийн хамгаалалтын далан суваг барьж байгуулах
- Гэр хорооллын доторхи авто замыг хатуу хучилттай болгох
- Хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох

Иргэдийн оролцоог дэмжих 2 дахь шатны төслийн тодорхой хэсгийг дүүргийн төлөвлөлтийг хийхэд ашиглахаар шийдвэрлэсэн ба эхний ээлжинд 3 дүүргийг сонгон авч дүүргийн түвшний хөгжлийн төлөвлөлтийг хийхээр бэлтгэл ажлыг хангаж байна.

Японы засгийн газрын буцалтгүй тусламжаар “Гамшгийн эрсдэлийг бууруулах” төслийг хэрэгжүүлэхээр Засгийн газартай Дэлхийн банк гарын үсэг зураад байна. Энэ төслийн хүрээнд үерийн хамгаалалтын далан сувгийг барьж байгуулах бүрэлдэхүүн хэсгийг дэмжих ба УБ хотын үерийн гамшгийн бэлэн байдлын үнэлгээ, стратеги, GIS мэдээллийн сан байгуулах, тоног төхөөрөмж хангах ажлыг энд багтаана. Нийслэлийн ИБХ, НОБГ, ОБЕГ-тай энэ төслийн талаар ярилцаж тохиролцоод байна.

Солонгосын засгийн газрын буцалтгүй тусламж нь Засгийн газраар хараахан батлагдаагүй байгаа ба энэхүү төсөл нь хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох бүрэлдэхүүн хэсгийг дэмжих юм. 500,000 ам. долларын өртөгтэй энэ төслөөр хог хаягдлын менежментийн шинэ механизмыг нэвтрүүлэх нэг хороог сонгон авч шаардлагатай тоног төхөөрөмжөөр ханган, туршилтын төсөл хэрэгжүүлэх юм. Чингэлтэй дүүргийн 12-р хороог одоогийн байдлаар сонгохоор нийслэлийн орчны бохирдол хог хаягдлын менежментийн хэлтэстэй ярилцаад байна.

6.5 ДҮГНЭЛТ

Нийслэл хотод ялангуяа гэр хорооллыг хөгжүүлэхэд чиглэгдэж байгаа зээл, буцалтгүй тусламжуудыг уялдуулах, харилцан бие биенээ нөхөх, шинэчилсэн засгийн газар, хотын бодлоготой уялдуулахаар ТҮН хөрөнгө оруулагч талтай хамтран ажиллаж байна.

УБНААСЗ төсөл, Иргэдийн оролцоог дэмжих төсөл, Гамшгийн эрсдэлийг бууруулах төсөл, Солонгосын засгийн газрын хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох төсөл хөтөлбөрүүд нь харилцан хамааралтай, бие биенээ дэмжсэн, гэр хорооллын хөгжилд дорвитой нэмэр болохуйц төслүүд учраас хотын захиргаа, харьяа байгууллагуудын дэмжлэг туслалцаа ихээхэн хэрэгтэй юм.

БҮЛЭГ 7. ЗАСАГ ДАРГЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД УБ-ЦЭВЭР АГААР, ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ДЭМЖИХ, ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ТӨСЛҮҮДЭЭР ТҮН-ИЙН ХИЙЖ ГҮЙЦЭТГЭХ АЖЛУУД /2013/

| № | 2013 онд НЗД-ын хэрэгжүүлэх үйл ажиллагаа | 2013 онд ТҮН-ийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Хугацаа | Оролцогч талууд | Хүрэх үр дүн |
|------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------|-------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Нэг. Агаар цэвэр Улаанбаатар | | | | | |
| 1.1 | Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр | | | | |
| 1.1.3 | Дулааны төвлөрсөн болон бие даасан эх үүсвэрээр хангах боломжгүй гэр хорооллын айл өрхүүдийг эрчим хүчний хэмнэлттэй зуух, боловсруулсан түлш болон утаа шүүгчээр хангана. | Эрчим хүчний хэмнэлттэй, ердийн халаалтын зуухыг гэр хорооллын 15.0 мянган өрхөд нийлүүлнэ. | 2013 оны халаалтын улирал | УБ цэвэр агаар төсөл НАЧА Дүүргүүд Цэвэр агаар сан | Гэр хорооллын иргэдийн 10 гаруй хувь “цэвэр” зуух хэрэглэснээр агаарын бохирдлыг зохих түвшинд бууруулна |
| 1.1.7 | Усан халаалтын болон технологийн зориулалт бүхий зуухнуудад бүртгэл хяналтын тогтолцоо нэвтрүүлж, технологийн шинэчлэл хийнэ | Усан халаалттай жижиг зуухнуудад зах зээлийн судалгаа хийж 2-3 загварыг сонгон авч технологийн шинэчлэлт хийнэ. Мөн усан халаалттай зуухны техникийн шалгуур үзүүлэлтийг боловсруулна. | IV улирал | УБ цэвэр агаар төсөл НАЧА НБХГ | Хүлээн зөвшөөрөгдөхүйц стандарт, техникийн шалгуур үзүүлэлттэй болно. |
| Зураг төсөв, ТЭЗҮ боловсруулах чиглэлээр | | | | | |
| 1.1.5 | Хотын тоосжилтыг бууруулах зорилгоор сул шороон хөрс бүхий гудамж, талбайг зүлэгжүүлэх эсхүл хатуу хучилттай болгох журам гаргаж мөрдүүлнэ | Нийслэл хотын ногоон байгууламжийн өнөөгийн байдалд үнэлэлт өгч цаашдын хөрөнгө оруулалтын ТЭЗҮБ судалгааг хийнэ. Үлгэр жишээ болохуйц | IV улирал | УБ цэвэр агаар төсөл ХНААХ ХТГ НБХГ | Цаашид хотын ногоон байгууламжид баримтлах бодлогын баримт бичиг бий болж, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөтэй болно. |

БҮЛЭГ VII. УЛААНБААТАР ХОТЫН НИЙТИЙН АЖ АХУЙГ САЙЖРУУЛАХ ТӨСЛИЙН 2013 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | 2013 онд НЗД-ын хэрэгжүүлэх үйл ажиллагаа | 2013 онд ТҮН-ийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Хугацаа | Оролцогч талууд | Хүрэх үр дүн |
|-------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------|----------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------|
| | | ногоон байгууламж барих нэг байршлыг сонгон авч загвар төсөл хэрэгжүүлэх бэлтгэлийг хангана. | | | |
| | | Цахилгаан станцуудын яндангаас гарч буй утааны бохирдол, үнсэн сангийн дэгдэмхий тоосонцрыг хэмжиж байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж байгаа нөлөөллийгн үнэлгээ хийнэ. Авах арга хэмжээг төлөвлөнө. | 2013-2014 | УБ цэвэр агаар төсөл ЭХЯ ТЭЦ I-IV | Тоос тоосонцрыг бууруулах цогц бодлого төлөвлөлтийг бий болгоно. |
| 1.1.2 | Гэр хорооллыг дахин төлөвлөх замаар айл, өрхүүдийг төвлөрсөн болон бие даасан эрчим хүчний эх үүсвэрт хэсэгчлэх холбох ажлыг үе шаттайгаар хийнэ | УБ хотын төвлөрсөн дулаан хангамжийн өсөн нэмэгдэж байгаа эрэлтэд суурилсан ТЭЗҮ боловсруулж, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө гаргана. | 2013-2014 | УБ цэвэр агаар төсөл ЭХЯ ДСК ОСНААГ | Дулаан хангамжийн ТЭЗҮ бэлэн болно. Цаашид авах арга хэмжээний төлөвлөгөө бэлэн болно. |
| 1.2 | Хөрс болон орчны бохирдлыг бууруулах чиглэлээр | | | | |
| 1.2.2 | Хотын хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөрийг хэрэгжүүлж, 2-оос доошгүй хог боловсруулах үйлдвэр байгуулна | Гэр хорооллын нэг хороог сонгон авч хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох загвар төслийг хэрэгжүүлнэ. | I-IV улирал | Солонгосын ЗГ буцалтгүй тусламж ЗАА-ны ОБХХМХ, ХТГ | Хороонд хог цуглуулах, зайлуулах шинэлэг арга механизм хэрэгжинэ. Цаашид хоггүй хороо байх жишиг тогтоно |
| 1.2.5 | Зуслангйн болон шинэ суурьшлийн бүсүүдэд хөрсний бохирдлоос хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлж, бие даасан | ЧД-ийн 18-р хороонд СИТИ ТУАЛЕТ барих ажлыг дуусган ашиглалтад хүлээлгэн өгнө. | I улирал | Иргэдийн оролцоог дэмжих төсөл УБ сан | Гэр хорооллын нийтийн зам талбайд цэвэр орчин бүрдэнэ. |

БҮЛЭГ VII. УЛААНБААТАР ХОТЫН НИЙТИЙН АЖ АХУЙГ САЙЖРУУЛАХ ТӨСЛИЙН 2013 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | 2013 онд НЗД-ын хэрэгжүүлэх үйл ажиллагаа | 2013 онд ТҮН-ийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Хугацаа | Оролцогч талууд | Хүрэх үр дүн |
|---------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------|--------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------|
| | инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц бий болгох ажлыг эхлүүлнэ | | | | |
| Хоёр. Амины орон сууцтай Улаанбаатар | | | | | |
| 2.1.2 | Иргэдийн оролцоотойгоор газар зохион байгуулалт, төлөвлөлтийн үйл ажиллагааг хэрэгжүүлж, барилга объект барихдаа тухайн нутаг дэвсгэрийн оршин суугчдын саналыг авдаг журамд шилжинэ. | 3 дүүргийн хөгжлийн төлөвлөлтийг иргэдийн оролцоотойгоор хийнэ. | I-IV улирал | Иргэдийн оролцоог дэмжих төсөл Дүүргүүд НБХБТГ | Дүүрэг бүр 5 жилийн хөгжлийн төлөвлөлттэй болно. |
| 2.3 | Орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх чиглэлээр | | | | |
| 2.3.1 | Улаанбаатар хотыг 2030 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний дагуу орон сууцны хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнүүдийг тодотгож нийтийн орон сууцны хөтөлбөрийг хэрэгжүүлнэ | Орлого багатай иргэд, нийгмийн эмзэг бүлгийнхэнд зориулсан “Боломжийн өртөгтэй орон сууцны стратеги боловсруулах” судалгааны ажлыг эхлүүлнэ. | 2013-2014 | Улаанбаатар-Цэвэр агаар төсөл БХБЯ НБХБТГ | Ерөнхий төлөвлөгөөтэй уялдсан орон сууцны стратеги төлөвлөгөөтэй болно. |
| Гурав. Ажилтай, орлоготой Улаанбаатар | | | | | |
| 3.1 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр | | | | |
| 3.1.1 | Нийслэл дүүргүүдийн хөдөлмөрийн биржийн үйл ажиллагааг идэвхижүүлэн байнгын, түр, цагийн ажлын байраар хангах, зөвлөгөө өгөх арга хэмжээг тогтмол хэрэгжүүлнэ. | Бүтээн байгуулалтад иргэдийн оролцоог хангах замаар 300 түр ажлын байрыг бий болгоно. | I-IV улирал | Иргэдийн оролцоог дэмжих төсөл Иргэдийн бүлгүүд Хороод | Гэр хорооллын ажилгүй, орлого багатай 300 иргэдийг ажлын түр байраар хангаж орлогыг нэмэгдүүлнэ. |
| 3.1.4 | Ахмад насны болон нийгмийн эмзэг бүлгийн иргэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өрх толгойлсон эхчүүдэд амьдрах | Гэр хорооллын 5 байршилд ногоон байгууламжийг бий болгох ажлыг иргэдийн оролцоотойгоор хийнэ. | III улирал | Иргэдийн оролцоог дэмжих төсөл Иргэдийн бүлгүүд | Амьдрах орчноо сайжруулахад иргэдийн оролцоог нэмэгдүүлж, ажлын байраар хангаж, |

БҮЛЭГ VII. УЛААНБААТАР ХОТЫН НИЙТИЙН АЖ АХУЙГ САЙЖРУУЛАХ ТӨСЛИЙН 2013 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | 2013 онд НЗД-ын хэрэгжүүлэх үйл ажиллагаа | 2013 онд ТҮН-ийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Хугацаа | Оролцогч талууд | Хүрэх үр дүн |
|-------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------|----------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------|
| | орчноо сайжруулах, байгаль орчноо нөхөн сэргээх ногоон ажлын байр бий болгох, хамтарч ажиллах боломжийг бүрдүүлнэ | | | Хороод | орлогыг нэмэгдүүлнэ. |
| 3.1.5 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асрах хөгжүүлэх төвийг дүүрэг бүрт байгуулна. | БЗД 8-р хороонд 18-20 насны залуучуудыг нийгэмшүүлэх 70 хүний багтаамжтай сургалтын төвийг дуусгаж ашиглалтад хүлээлгэн өгнө. | I улирал | Иргэдийн оролцоог дэмжих төсөл ХЗСХТ | 70 орчим нийгмийн халамж шаардсан эмзэг бүлгийн хүүхдүүдийг нийгэмшүүлэх, мэргэжлийн чиг баримжаа олгоход туслана. |
| Дөрөв. Аюулгүй, амгалан Улаанбаатар | | | | | |
| 4.2.3 | Нийтийн эзэмшлийн гудамж талбай, явган зам, нийтийн үйлчилгээний газруудад гэрэлтүүлэг, аюулгүй байдлын хяналтын сүлжээ бий болгоно. | Гэр хорооллын 17 айлын хашаанд гудамжны гэрэлтүүлэг тавьж ашиглалтыг иргэдийн бүлгээр хариуцуулна. Нийтийн тээврийн автобусны зогсоол 6 байршилд иргэдийн оролцоотойгоор барина. | III улирал | Иргэдийн оролцоог дэмжих төсөл Иргэдийн бүлгүүд | Аюулгүй орчин бүрдүүлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлж, ажлын байраар хангаж орлогыг нэмэгдүүлнэ. |
| 4.3 | Автозам тээврийн сүлжээг хөгжүүлэх чиглэлээр | | | | |
| 4.3.5 | Гэр хорооллын доторх авто замын сүлжээг сайжруулж хатуу хучилттай авто зам барина. | БЗД 5-р хороо, Монелийн 4-р гудамжаар өгсүүлэн 1,2 км авто зам гэрэлтүүлэг, ус зайлуулах байгууламжийн хамт барьж хүлээлгэн өгнө. | IV улирал | Иргэдийн оролцоог дэмжих төсөл Иргэдийн бүлгүүд | Гэр хорооллын дэд бүтэц сайжирна |
| 4.4 | Гамшгаас хамгаалах чиглэлээр | | | | |
| 4.4.4 | Үерийн ус зайлуулах далан суваг, тогтоолцоог сайжруулж, нэмж байгуулна | СХД-ийн 9-р хорооны Баруун баян уулын сувгийн 400м үерийн хамгаалалтын | I улирал | Иргэдийн оролцоог дэмжих төсөл НХОГ | Нийслэл хотын үерийн гамшгийн бэлэн байдлыг нэмэгдүүлнэ. |

БҮЛЭГ VII. УЛААНБААТАР ХОТЫН НИЙТИЙН АЖ АХУЙГ САЙЖРУУЛАХ ТӨСЛИЙН 2013 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | 2013 онд НЗД-ын хэрэгжүүлэх үйл ажиллагаа | 2013 онд ТҮН-ийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Хугацаа | Оролцогч талууд | Хүрэх үр дүн |
|-------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------|-----------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------|
| | | далан сувгийн ажлыг дуусган хүлээлгэн өгнө. | | | |
| | | УБ хотын үерийн гамшгийн бэлэн байдалд үнэлгээ өгч GIS –т суурилсан мэдээллийн бааз бий болгож үерт өртөмтгий газруудын зураглал хийнэ | 2013-2014 | Гамшгийн эрсдэлийг бууруулах төсөл ОБЕГ НОБГ ИБХ | |
| | | Үерийн гамшгаас хамгаалах шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана. | IV улирал | Гамшгийн эрсдэлийг бууруулах төсөл ОБЕГ НОБГ ИБХ | |
| 4.4.2 | Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд олон нийтийн бэлэн байдлыг нэмэгдүүлэх орон нутгийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ. | Авран хамгаалах, чадавхийг дээшлүүлэх сургалт зохион байгуулна. | IV улирал | Гамшгийн эрсдэлийг бууруулах төсөл ОБЕГ НОБГ ИБХ | |
| | | Үерийн гамшгийн эрсдэлийн бууруулах стратеги боловсруулна | 2013-2014 | Гамшгийн эрсдэлийг бууруулах төсөл ОБЕГ НОБГ ИБХ | Үерийн гамшгийн эрсдэлийг бууруулах цогц бодлогын баримт бичигтэй болно |

ХОЛБОО БАРИХ

Хаяг : Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Энхтайваны өргөн чөлөө-50, 1-р хороо,
Азмон төв (1-р төрөхийн зүүн талд),
6 давхар, Улаанбаатархот, Монгол улс

Утас : 976-11-312194

Факс : 976-11-312194

Имэйл: to_pmu@usip.mn

Вэбсайт: <http://www.usip.mn>

<http://www.facebook.com/usip.pmu>